

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
**2024 оны 12 дугаар сарын 26-ны өдөр, Пүрэв гараг**

<b>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</b>	0
<b>Хуралдааны товч тэмдэглэл:</b>	1-10
<b>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</b>	11-31

- 
1. **“Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд Гашуун сухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх хэлэлцээрийг байгуулахад баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.12.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/**
- 11-31

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы  
Эдийн засгийн байнгын хорооны  
12 дугаар сарын 26-ны өдөр /Пүрэв гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Эдийн засгийн байнгын хорооны дарга Р.Сэддорж ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 21 гишүүн хүрэлцэн ирж, 84.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 20 цаг 25 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: М.Бадамсүрэн, Ш.Бямбасүрэн;  
Тасалсан: Х.Баттулга, Х.Ганхуяг.

**Нэг. “Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд Гашуун сухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх хэлэлцээрийг байгуулахад баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.12.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан, Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Жавхланбаатар, мөн яамны Эрдэс баялгийн бодлогын газрын дарга Г.Намчинсүрэн, Хуулийн хэлтсийн дарга Т.Ганбаатар, Ашиглалт, ногоон хөгжлийн хэлтсийн дарга Б.Хулан, Зам, тээврийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Артур, мөн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлого, зохицуулалтын газрын дарга Х.Итгэлт, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Гүйцэтгэх захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Х.Мөнхжаргал, мөн компанийн Уул уурхай, технологийн газрын дарга Ч.Алтанбагана, Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын газрын дарга Э.Түвшинжаргал, Борлуулалт, маркетинг, тээврийн газрын дарга О.Цэрэндондог нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, мөн газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх О.Одончимэг, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг нар байлцав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан, Ж.Алдаржавхлан, Д.Энхтүвшин нарын тавьсан асуултад Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Жавхланбаатар, Зам, тээврийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Артур, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Гүйцэтгэх захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Х.Мөнхжаргал нар хариулж, тайлбар хийв.

Хуралдаан 20 цаг 37 минутаас 20 цаг 52 минутад завсарлав.

**Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу** “Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх хэлэлцээрийг байгуулахад баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг заалт бүрээр хэлэлцэв.

Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

**Р.Сэддорж:** 1.Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалангийн гаргасан, Тогтоолын төслийн 1 дэх заалтын 2 дахь дэд заалтын “гурван асуудлыг харилцан уялдаатай цогц байдлаар хамтад нь шийдвэрлэх” гэснийг “арга хэмжээг уялдуулан шийдвэрлэх” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан гаргасан саналаа тайлбарлаж, үг хэлэв.

Зөвшөөрсөн: 3  
Татгалзсан: 18  
Бүгд: 21

14.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалангийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 19.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

2.Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалангийн гаргасан, Тогтоолын төслийн 1 дэх хэсгийн 3 дахь заалтад “хамтын ажиллагаанд “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцаа, эзэмшиж байгаа ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг бусад этгээдэд шилжүүлэхгүй байх” гэснийг “ажлыг Эрдэнэс Тавантолгой” ХК хариуцан зохион байгуулах хүрээнд оператор аж ахуйн нэгжийг нээлттэй сонгон шалгаруулах” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан гаргасан саналаа тайлбарлаж, үг хэлэв.

Зөвшөөрсөн: 4  
Татгалзсан: 17  
Бүгд: 21

19.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэг, С.Цэнгүүн нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 28.6 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

3.Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалангийн гаргасан, Тогтоолын төслийн 1 дэх хэсгийн 4 дүгээр заалт “тогтоохдоо” гэсний дараа “зах зээлийн үнийг харгалзан” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан гаргасан саналаа тайлбарлаж, үг хэлэв.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 13  
Бүгд: 21  
38.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

4. Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргалын гаргасан, Тогтоолын төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалтын “16 хүртэл жилээр тогтоох” гэсний дараа “нүүрсийг “Ганц мод” боомт нөхцөлөөр нийлүүлэх, тээврийг Монголын тал хариуцан гүйцэтгэх агуулгаар тохиролцох” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргал гаргасан саналаа тайлбарлаж, үг хэлэв.

Зөвшөөрсөн: 4  
Татгалзсан: 17  
Бүгд: 21  
19.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Найдалаа, Д.Энхтүвшин нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 28.6 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

5. Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргалын гаргасан, Тогтоолын төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалт “жишиг болгож” гэснийг “зах зээлийн өнөөгийн нөхцөлд нийцүүлэн өөрчилж, суурь үнийг шинэчилж, үнийн индексийг Бүгд Найрамдах Хятад Ард Улсын болон олон улсын зах зээл дээрх үнийн мэдээлэл, Монголын хөрөнгийн биржээр худалдаалсан нүүрсний үнийн мэдээллийг ашиглан тооцоолох” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргал гаргасан саналаа тайлбарлаж, үг хэлэв.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 13  
Бүгд: 21  
38.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

6. Улсын Их Хурлын гишүүн Г.Очирбатын гаргасан, Тогтоолын төслийн 1 дэх хэсэгт дараах заалтыг нэмэх:

“12.Монгол Улсын тэргүүлэх чиглэлийн 14 мега төслийн “Хэрлэн тооно” ус дамжуулах шугам хоолой татах бүтээн байгуулалтын ажлыг хамтран гүйцэтгэх гэрээ, хэлцлийг 2025 оноос эхлэхээр зохион байгуулалтын арга хэмжээ авах” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Улсын Их Хурлын гишүүн Г.Очирбат гаргасан саналаа тайлбарлаж, үг хэлэв.

Зөвшөөрсөн: 5  
Татгалзсан: 16  
Бүгд: 21  
23.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэгийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 28.6 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

7.Улсын Их Хурлын гишүүн Г.Очирбатын гаргасан, Тогтоолын төслийн 1 дэх хэсгийн 5 дахь дэд заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“Гашуун сухайт-Ганц мод чиглэлийн төмөр замын тээврийн хүчин чадал, эдийн засгийн үр өгөөжийг хангах зорилгоор Нүүрс худалдах, худалдан авах гэрээний дагуу нийлүүлэх нүүрсний хэмжээг 2025-2029 онд нийт 27 сая тонн /үүнээс 7 сая тонн нь “Эрдэнэс Тавантолгой”-н баяжуулах үйлдвэрээс гарч байгаа баяжуулсан нүүрс/, 2030 оноос эхлэн жилд 20 сая тонн /үүнээс 5 сая тонн нь баяжуулах үйлдвэрийн баяжуулсан нүүрс/-оос бууруулахгүй байх” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Г.Очирбат гаргасан саналаа тайлбарлаж, үг хэлэв.

Зөвшөөрсөн: 5  
Татгалзсан: 16  
Бүгд: 21  
23.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

8.Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргалын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалтын “бууруулахгүй байх” гэсний өмнө “Монгол Улсаас Бүгд Найрамдах Хятад Ард Улсаас нийлүүлэх нүүрсний нийт хэмжээг 120 сая тонноос багагүй хэмжээнд хүргэх тохиролцоо хийх” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргал гаргасан саналаа тайлбарлаж, үг хэлэв.

Зөвшөөрсөн: 4  
Татгалзсан: 17  
Бүгд: 21  
19.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

9.Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргалын гаргасан, Тогтоолын төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалт “бууруулахгүй байх” гэсний дараа “, “Эрдэнэс Тавантолгой” компанийн уурхай олборлолтын төлөвлөгөөтэй нийцүүлэн коксжих, сул коксжих, эрчим хүчний нүүрсийг зохимжит хувь харьцаагаар нийлүүлэх буюу зөвхөн нэг төрлийн нүүрсийг сорчлохгүй байх” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргал гаргасан саналаа тайлбарлаж, үг хэлэв.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 10  
Бүгд: 21  
52.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

10. Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалангийн гаргасан, Тогтоолын төслийн 1 дэх хэсгийн 7 дугаар заалтын “бүтээн байгуулалтад “Нэг зураг төсөлтэй, нэг гүйцэтгэгчтэй, бүтээн байгуулалтыг зэрэг эхлүүлж, зэрэг дуусгах зарчим баримтлах” гэснийг хасаж, “бүтээн байгуулалтыг нэгдсэн зураг төсөл төлөвлөгөөний дагуу нэгдсэн байдлаар гүйцэтгэх зарчмыг баримтлах” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан гаргасан саналаа тайлбарлаж, үг хэлэв.

Зөвшөөрсөн: 3  
Татгалзсан: 18  
Бүгд: 21  
14.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

11. Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалангийн гаргасан, Тогтоолын төслийн 1 дэх хэсгийн 8 дахь заалтыг бүхэлд нь хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан гаргасан саналаа татаж авсан тул санал хураалт явуулаагүй болно.

12. Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалангийн гаргасан, Тогтоолын төслийн 1 дэх хэсгийн 9 дэх заалтыг бүхэлд нь хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан гаргасан саналаа тайлбарлаж, үг хэлэв.

Зөвшөөрсөн: 4  
Татгалзсан: 17  
Бүгд: 21  
19.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэг, С.Цэнгүүн нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 28.6 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

13. Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалангийн гаргасан, Тогтоолын төслийн 1 дэх хэсгийн 10 дугаар заалтын “үе шаттайгаар” гэснийг “зэрэг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан гаргасан саналаа тайлбарлаж, үг хэлэв.

Зөвшөөрсөн: 15  
Татгалзсан: 6  
Бүгд: 21  
71.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэлийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 76.2 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдалын гаргасан, Тогтоолын төслийн 1 дэх заалтын 10 дахь дэд заалтын “харилцах ашигтай” гэсний дараа “хувилбарт шийдэл бүхий гэрээний хүрээнд” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал гаргасан саналаа тайлбарлаж, үг хэлэв.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 10  
Бүгд: 21  
52.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлангийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан, Тогтоолын төслийн 1 дэх заалтад 11 гэсэн шинэ дэд заалт нэмэх:

“11.Байтаг-Улиастайн боомтыг байнгын үйл ажиллагаатай болгох, Булган Такашкен боомтод улсын хилийн 126, 127 дугаар тэмдгийн хооронд авто замаар улсын хилийн шугамыг дайран өнгөрөх цэгийг тохирон хилийн гарц шинээр нэмэх, нүүрс ачиж буулгах талбай, ачаа, тээврийн терминал болон улсын хил дамнасан авто замын бүтээн байгуулалтын ажлыг үе шаттайгаар эхлүүлэх талаар Бүгд Найрамдах Хятад Ард Улсын талтай тохиролцох.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13  
Татгалзсан: 8  
Бүгд: 21  
61.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн М.Мандхайгийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

16. Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн гаргасан, Төслийн 1 дэх заалтад 12 дахь дэд заалт нэмэх:

“12. Төмөр замын дамжин өнгөрөх тээврийн хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр байгуулах ажлыг анхаарах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг гаргасан саналаа тайлбарлаж, үг хэлэв.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 11  
Бүгд: 21  
47.6 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшингийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Р.Сэддорж:** Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшингийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 10  
Бүгд: 21  
52.4 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Р.Сэддорж:** Горимын санал дэмжигдсэн тул дээрх саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13  
Татгалзсан: 8  
Бүгд: 21  
61.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэгийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

17. Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн гаргасан, Тогтоолын төслийн 1 дэх заалтад “Бүтээн байгуулалтын болон олборлолтын бүх л үе шатанд Монгол улсын аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг гаргасан саналаа тайлбарлаж, үг хэлэв.

Зөвшөөрсөн: 12  
Татгалзсан: 9  
Бүгд: 21  
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.



18. Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлангийн гаргасан, Тогтоолын төслийн 1 дэх заалтад “Төмөр замын ачаа тээвэрт 2 тал тэгш эрхтэй байх, Монгол Улсын бусад компаниудын ачааг тээвэрлэх боломжтой байх.” гэсэн дэд заалт шинээр нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлан гаргасан саналаа тайлбарлаж, үг хэлэв.

Зөвшөөрсөн: 15  
Татгалзсан: 6  
Бүгд: 21  
71.4 хувийн саналаар дэмжигдлээ.

19. Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшингийн гаргасан, Тогтоолын төслийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтад “Төмөр замын бүтээн байгуулалтын” гэснийг “төмөр замын тээврийн хүчин чадал” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин гаргасан саналаа тайлбарлаж, үг хэлэв.

Зөвшөөрсөн: 13  
Татгалзсан: 8  
Бүгд: 21  
61.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлангийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

20. Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддоржийн гаргасан, Тогтоолын төслийн 1 дэх заалтын 11 дэх дэд заалтын “сэргээгдэх эрчим хүчний экспорт, эрчим хүчний нүүрс экспортлох, нүүрсний гүн боловсруулах аж үйлдвэржилт, говийг усжуулах, шар шороон шуурга, цөлжилттэй тэмцэх, хил холболт болон дэд бүтцийн бүтээн байгуулалт” гэсний дараа “орон нутгийн хөгжлийг дэмжих, орон нутагт ажлын байр шинээр бий болгох” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15  
Татгалзсан: 6  
Бүгд: 21  
71.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалангийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 76.2 хувийн саналаар дэмжигдлээ.

21. Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддоржийн гаргасан, Тогтоолын төслийн 3 дахь заалтын “Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо /Г.Тэмүүлэн/-д” гэсний дараа “Эдийн засгийн байнгын хороо” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 17  
Татгалзсан: 4  
Бүгд: 21  
81.0 хувийн саналаар дэмжигдлээ.

22. Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддоржийн гаргасан, Дээрх саналууд дэмжигдсэнтэй холбогдуулан тогтоолын төслийн дугаарыг өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 16  
Татгалзсан: 5  
Бүгд: 21  
76.2 хувийн саналаар дэмжигдлээ.

23. Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшингийн гаргасан, Тогтоолын төслийн “Монгол Хятадын хилийн Гашуун сухайт-Ганц мод чиглэлийн төмөр замын тээврийн” гэснийг “Монгол Хятадын хилийн Гашуун сухайт-Ганц мод боомтын хил дамнасан төмөр зам” гэж тухай бүрд жигдлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин гаргасан саналаа тайлбарлаж, үг хэлэв.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 13  
Бүгд: 21  
38.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

24. Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшингийн гаргасан, Тогтоолын төслийн “эдийн засгийн үр ашиг” гэснийг “эдийн засгийн үр өгөөж” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 12  
Бүгд: 21  
42.9 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

25. Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшингийн гаргасан, Тогтоолын төслийн “тээврийн багтаамж” гэснийг “тээврийн хүчин чадал” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13  
Татгалзсан: 8  
Бүгд: 21  
61.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Тогтоолын төслийг заалт бүрээр хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ч.Лодойсамбуу Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 22 цаг 16 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 1 цаг 36 минут үргэлжилж, ирвэл зохих 25 гишүүнээс 21 гишүүн хүрэлцэн ирж, 84.0 хувийн ирцтэйгээр 22 цаг 16 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**  
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА

Р.СЭДДОРЖ

**Тэмдэглэл хөтөлсөн:**  
ХУРАЛДААН ЗОХИОН  
БАЙГУУЛАХ ХЭЛТСИЙН  
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 12 дугаар сарын 26-ны өдөр, Пүрэв гараг  
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан” танхим,  
20 цаг 25 минут

### ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Р.Сэддорж:** Байнгын хорооны эрхэм гишүүдийн оройн амгаланг айлтгая. Хуралдаанд оролцож байгаа гишүүдийн ирц 84 хувьтай байна. Ингээд ирсэн гишүүд протоколд тэмдэглэгдэж байгаа учраас Улсын Их Хурлын гишүүн Сэддорж, Алдаржавхлан, Батболд, Батнайрамдал, Батчимэг, Батшугар, Мандхай, Мөнхсоёл, Соронзонболд, Найдлаа, Энхтүвшин, Энхцэцэг, Ундраа, Ундраа гишүүд хүрэлцэн ирсэн байна. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, Байнгын хорооны ирц 84 хувьтай бүрдсэн тул Эдийн засгийн байнгын хорооны 2024 оны 12 сарын 26-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг та бүхэндээ танилцуулъя. Хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэг.Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд Гашуун сухайт-Ганц мод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх хэлэлцээрийг байгуулахад баримтлах үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүд байна уу. Байхгүй байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

**“Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд Гашуун сухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх хэлэлцээрийг байгуулахад баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж эхэлье.**

Ажлын хэсгийг танилцуулъя. Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд яг одоо Үндэсний телевизээр тухай мэдэгдэл шууд нэвтрүүлэгт орохоор давхардаж байгаа юм байна. Ингээд Төрийн нарийн бичгийн дарга ирсэн үү. Жавхланбаатар тус яамны Төрийн нарийн бичгийн дарга, Хулан тус яамны Ашиглалт ногоон хөгжлийн хэлтсийн дарга, Дэлгэрсайхан Зам, тээврийн хөгжлийн сайд, Артур тус яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Итгэл тус яамны Төмөр зам, далайн тээврийн бодлогын зохицуулалтын газрын дарга, “Эрдэнэс Тавантолгой” компаниас Мөнхжаргал “Эрдэнэс Тавантолгой” компанийн гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Түвшинжаргал “Эрдэнэс Тавантолгой” компанийн Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын газрын дарга, Цэрэндондог “Эрдэнэс Тавантолгой” компанийн Борлуулалт, маркетинг, тээврийн газрын дарга гэсэн ийм бүрэлдэхүүн ирсэн байна.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд нэрсээ өгнө үү. Энхтүвшин гишүүнээр тасалъя. Батбаярын Жаргалан гишүүн асуулт.

**Б.Жаргалан:** Та бүхэнд оройн мэнд хүргэе. Шууд тогтоолын төслийнхөө нэг үг үсэг рүү орчихъё гэж бодож байна. Нэг дэх хэсгийн энэ 1 дүгээр заалт дээр аливаа гуравдагч талын оролцоогүйгээр гэсэн нэг үг байгаад байгаа юм. Яг энийг би яг ерөөсөө нарийн учрыг нь ойлгохгүй байгаад байгаа юм. Энийг нэг тайлбарлаж өгнө үү.

2-т 3 дугаар заалт дээр болохоор “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцаа эзэмшиж байгаа ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг бусад этгээдэд шилжүүлэхгүй байх гэсэн нэг ийм үг байгаад байгаа юм. Энэ бас яг ямар логиктой үг юм бэ. Заавал жишээлбэл Монгол Улсын Их Хурал Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгч байхад ийм ТӨК-ийн хувьцааг ингэж тэгж болохгүй шүү гэсэн ийм чиглэл өгөх нь хэр зохимжтой вэ.

4 дүгээр заалт дээр болохоор нөгөө урт хугацаатай гэрээнүүдийн нөхцөл үнийн аргачлалыг жишиг болгоно гээд байгаа шүү дээ. Энэ дээрээ нэг ийм тодорхой тэр дискаунтлагдаж байгаа хувь хэмжээгээ тавих талаар ер нь бодолцож үзсэн үү. Тэгээд сая Ерөнхий сайд бол танилцуулга дээрээ бид бол энэ гэрээг байгуулаад энэ хэлэлцээрийг байгуулаад тэгээд цаашдаа бусад боомтуудаа нээгээд явсны хүчинд бол энэ нүүрсний олборлолтыг бол 100 саяас давуулаад цаашлаад 165 сая гэдэг тийм тоо хэлсэн. Тэгэнгүүт зөвхөн “Чайна Энержи”-тэй байгуулж байгаа гэрээний тоог оруулахаас гадна цаашдаа бол бусад боомтуудаар ийм ийм нүүрс худалдаж авна гэсэн тийм заалт оруулах боломж байгаа юу, үгүй юу.

Би 5 дугаар заалтын тухайд яриад байна л даа. Тэгэхээр энэ нэгэнтээ Засгийн газар хоорондын хэлэлцээр юм чинь зөвхөн “Чайна Энержиг”-ийн асуудал биш, ер нь цаашдаа боомтуудаа нэмэгдүүлээд, энэ хилийн гарцуудаа нэмэгдүүлсний дараа ер нь жилд 100 сая тонныг ингэж ингэж авна ч гэдэг юм уу нэг тиймэрхүү маягийн зүйл оруулах боломж байгаа юу. Байсан уу.

Тэгэнгүүт энэ 8 дугаар заалт дээр энэ бүтээн байгуулалтын төслийн ажлыг Хятадын талын сонгон шалгаруулсан аж ахуйн нэгжээр гэсэн нэг ийм үг яваад байгаа юм. Энэ заавал шаардлагатай юу.

10 дугаар заалтын хувьд болохоор бусад боомтуудынхаа төмөр замаар холбох ажлыг үе шаттайгаар эхлүүлэх тохиролцоонд хүрэх гээд энэ бол манай талын гол заалт байх гэж ойлгож байгаа. Тэгэхээр энэ дээр энэ үе шаттайгаар гэдэг, тэгээд энэ тохиролцоонд хүрэх энэ тэр гэдгээ илүү нарийвчилж томъёолох нь зөв биш үү. Жишээлбэл зэрэг эхлүүлэх гээд сая бас чуулган дээр манай зарим гишүүд ярьсан. Тэгээд энэ үг, үсгийн хувьд болохоор ерөнхийдөө бол илүү тийм ерөнхийлсөн байдлаар бас зарим зүйлүүдээ оруулсан нь зөв санагдаж байна.

**Р.Сэддорж:** Хариулъя. Дэлгэрсайхан сайд, дараа нь Уул уурхайн яам.

**Б.Дэлгэрсайхан:** Би эхний асуусан энэ 3 заалтыг нь хариулъя. Тэгээд үлдсэнийг нь бас манай ажлын хэсгийнхэн хариулах байх. Энэ Жаргалан гишүүний асуусан асуултын энэ 2 дугаарт буюу Монгол Хятадын хилийн Гашуун сухайт-Ганц мод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын эдийн засгийн үр ашгийг хангах зорилгоор төмөр замын бүтээн байгуулалт, нүүрс худалдах, худалдан авах урт хугацааны гэрээг байгуулах, уурхайн хүчин чадал нэмэгдүүлэх гурван асуудлыг уялдаатай. Энэ биш юм байна. Энэ дээд талынх нь байна

уучлаарай. Гуравдагч талыг оролцуулахгүйгээр хэрэгжүүлэх гэж 1 дүгээр заалтад байгаа нь юу гэж байгаа юм бэ гэхээр зэрэг ер нь бол манайх энэ том бүтээн байгуулалтуудаа ихэнхдээ дандаа зуучлагчтайгаар юм уу дандаа гуравдагч орон орж ирдэг, эсвэл гуравдагч бүтээн байгуулалт хийх нэрээр ингээд орж ирдэг юмыг л хязгаарлая гэж байгаа юм. Ингэвэл нөгөө барих өртөг нь одоо хоорондоо бизнесээ хийх өртөг мөнгө нь ч гэсэн бас дундаас нь хумслаад байхгүй гэдэг утгаар энэ агуулгыг оруулж ирсэн шүү гэдгийг хэлье.

2 дугаарт нь бол мөн ялгаагүй 2.3-д заасан ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг бусад этгээдэд шилжүүлэхгүй байх гэдгийг яагаад хувьцааг Тавантолгойн хувьцаа болон эзэмшиж байгаа ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг бусдад шилжүүлэхгүй байх гэдгийг яагаад оруулсан юм гэхээр зэрэг энэ анх урд хөршийн тавьсан “Чайна Энержи”-ийн анх оруулж ирсэн санал дээр бол бид хувь эзэмшинэ, тэгээд тусдаа давуу эрх эдэлж орно гэсэн ийм санал байсан юм. Тэгэхээр нэгэнт энэ саналаасаа татгалзсан учраас бид зориуд энийг оруулж ингээд хааж өгч байгаа гэсэн үг. Өөрөөр хэлбэл манай талын хаалт гэсэн үг байхгүй юу. Ингээд хожмоо юм ахиад сөхөгдөж магадгүй учраас нэгэнт зөвшөөрсөн дээр нь ийм заалтаар хааж өгвөл хожим нь энэ асуудал дахиж босож ирэхгүй гэдэг ийм юм байгаа юм гэдгийг бас ойлгоорой.

Дараагийн дугаарт бас энэ төмөр замтай холбоотой байна. Энэ төмөр замыг нэг аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулж гэж асуусан. Тийм ээ. 8 дугаар зүйлийг асуух шиг болсон. Гашуун сухайт-Ганц мод хил боомтын хил дамнасан төмөр зам барих, түүнийг холбох бүтээн байгуулалтын төслийн ажлыг Хятадын талын сонгон шалгаруулсан аж ахуйн нэгжээр төмөр зам, түүний холбох байгууламжийг гүйцэтгүүлэн хамтран ажиллана гэж байгаа юм. Яагаад .../минут дуусав/

**Р.Сэддорж:** Гүйцээж хариулъя. Дэлгэрсайхан сайд.

**Б.Дэлгэрсайхан:** Энийг ингэж оруулж өгдөг нь энэ өөрөө нэг байгууламж юм байгаа юм. Одоо ингээд 2 тусдаа тендер зарлаад хийнэ гэвэл энэ холболт бол хэзээ ч бүтэхгүй зүйл өөрөөр хэлбэл. Тийм учраас 2 юмыг холбох гэж байгаа учраас 2 талаасаа 1 л компаниар хийлгэе гэдэг санааг оруулж өгч байгаа юм. Тийм учраас энийг тэртээ тэргүй хийж чадах газар нь бол урд хөршийн гүүр барьдаг тусгай зориулалтын компани байгаа учраас бид нар ч гэсэн энийг нь хүлээн зөвшөөрч байгаа юм. Яагаад вэ гэхээр дараа нь ямар нэгэн эрсдэл гарвал урд тал энийгээ өөрөө хариуцна. Энэ гэрээнд энийг заана шүү дээ. Энэ чинь ингээд бүтээн байгуулалт хийх явцад тэгээд 2,5 жил бүтээн байгуулалтаа хийгээд, 6 сарын турш энэ чинь туршилт хийнэ гэж байгаа юм.

**Р.Сэддорж:** Баярлалаа. Жаргалан гишүүний асуулт үргэлжилнэ. Яг одоо энд гишүүд хэдүүлээ энэ хаалгаар ороод санал хураалт болох гэж байгаа юм байна. Санал хураалтад орчхоод эргэж ирж үргэлжлүүлье. Ажлын хэсгийг эндээ байж байгаарай.

ЗАВСАРЛАГА.

**Р.Сэддорж:** Жаргалан гишүүний асуултад үргэлжлүүлж хариулна. Сая Дэлгэрсайхан сайд хариулсан. Одоо Жавхланбаатар дарга. 4 номер.

**С.Жавхланбаатар:** Жаргалан гишүүний асуултад хариулъя. Бусад боомтууд дээр нүүрсний хэмжээ тогтоож болох уу гэсэн асуулт байсан. Энэ удаагийн хэлэлцээр маань 2 улсын хоорондох Засгийн газар хоорондын хэлэлцээр маань зөвхөн Гашуун сухайт-Ганц мод холболтын төслийг ярьж байгаа 1 дүгээрт, 2 дугаарт бол яах вэ, бид нар бас бусад боомтуудаа яриагүй биш хэлэлцээнд яриад явж байгаа. Бусад боомтуудын харин нүүрсийг бол тогтоох одоогоор бол боломжгүй. Тухайн боомтуудын холболтын асуудал ярихад нүүрсний экспортыг нэмэгдүүлэх асуудлыг ярьж болно гэж ингэж харж байгаа. Үнийн асуудлаар Эрдэнэс Тавантолгой нэмээд хариулчих уу.

**Р.Сэддорж:** “Эрдэнэс Тавантолгой” компани Мөнхжаргал захирал. 5 номер.

**Х.Мөнхжаргал:** Жаргалан гишүүний асуултад хариулъя. Энэ нь тухайн төсөлтэй холбоотойгоор бол “Чайна Энержи” компаниас ажлын хэсэгт яг бид нар энэ үнийг дагана гээд манай хамгийн урт хугацаатай гэрээ, мөн удаан хугацааны худалдан авагч болох “Чалко” компанийн үнийг бид нар баримтална гэдэг санал ирүүлсэн байгаа. Тэгээд яах вэ, манай байгууллагын зүгээс бол тухайн санал дээр ерөнхийдөө ажиллаж байгаа. Одоо яг тухайн санал дээр ямархуу байдлаар шийдвэр гаргаад явах вэ гээд.

“Чалко” компанийн хувьд бол угаасаа анхнаасаа энэ компаниа 2011-2013 онуудад зөвхөн “Чалко” компани нүүрс авдаг байж байгаад, 2014 оноос өөр худалдан авагч нар орж ирсэн байдаг. Тухайн үед бол зөвхөн энэ компанийн нүүрсний үнэ бол “Чалко” компанийн худалдаж авч байсан нүүрсний үнээр тодорхойлогддог байсан юм байна лээ. Тэгэхээр яах вэ, ажлын хэсгийн зүгээс энэ үнийн аргачлал дээр нь ерөнхийдөө ажиллаж байгаа гэж ойлгож болно. Баярлалаа.

**Р.Сэддорж:** Жаргалан гишүүн тодруулъя.

**Б.Жаргалан:** Тэгэхээр энэ тогтоол болохоор Монгол Улсын Их Хурлаас Монгол Улсын Засгийн газарт энэ хэлэлцээр байгуулахад баримтлах үүрэг чиглэл өгч байгаа тогтоол. Тэгэхээр манай талын бас эрх ашиг үүн дээр бас тодорхой байдлаар туссан байх ёстой. Тэгэхээр энэ 11 заалт дээр аль нь манай эрх ашиг вэ, аль нь аль эрх ашиг вэ энэ тэр гэдэг нь бол бас харагдаж л байна л даа. Тэгэхээр бас өөрсдийнхөө эрх ашигтай холбоотой юмнуудыг бол нэлээн хүчтэй байдлаар томъёолох нь зүйтэй гэж харж байгаа. Тэгэхээр энд бас зарчмын зөрүүтэй санал дээр хэд хэдэн найруулгын бөгөөд ийм зүйлүүд бол бас бэлдээд авчирлаа л даа. Тэгээд сая ажлын хэсгийн хариултаар болохоор хэтэрхий бас бөөрөнхий, ийм ойлгомжгүй л байгаад байна. Тэгэхээр зарчмын зөрүүтэй саналуудаа одоо өгчхөж болно шүү дээ. Тийм ээ.

**Р.Сэддорж:** Нэмж хэн хариулах вэ. Жавхланбаатар дарга. 4 номер.

**С.Жавхланбаатар:** Жаргалан гишүүний байр суурин дээр тодруулж хэлэхэд бол тогтоолын маань угаасаа нэр нь энэ 2 Засгийн газар хооронд Гашуун сухайт-Ганц мод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалт л гээд байгаа юм. Тийм учраас тэгэхдээ дотор нь бол бид нар нөгөө яг гэрээний төсөл орж ирнэ шүү дээ. Гэрээний төсөл орж ирэхэд бол бусад боомтын талаар бас аль болох өндөр тохиролцоонд хүрээд, нарийвчилж үг үсэгтэй нь орж ир гэж байгаа юм. Бас нэг зүйл гишүүддээ хэлэхэд бол хэрэв хэт нарийлсан, нарийвчилсан өндөр байр

суурь тавьчих юм бол магадгүй бид нар нөгөө талтайгаа тохиролцоонд хүрэхгүй харин гацчих бас эрсдэл байгаа шүү гэдгийг бодолцоорой л гэж хэлэх гэсэн юм. Баярлалаа.

**Р.Сэддорж:** Жуковын Алдаржавхлан гишүүн.

**Ж.Алдаржавхлан:** Би санал хураалгахгүй өмнө 2 зүйл тодруулах гэсэн юм. 27 сая тонныг гаргана гэж байгаа шүү дээ. 27 сая тонныг гаргана гэж байгаа 4 жилийн хугацаанд, 5 жилийн хугацаанд. Тэрэндээ хүрэхгүй бол яах вэ гэдэг асуулт байна. Хүрэхгүй бол, илүү гарчихвал яах вэ гэж. Энэ чинь яг хатуу заачихсан байна шүү дээ 27 сая тонн гээд.

2 дугаарт Монгол Улсын 2030 оноос хойш жил бүр 20 сая тонноос бууруулахгүй гэж байгаа юм. Ер нь та хэд ажлын хэсгийн хувьд юу гэж үзэж байгаа юм. Монгол Улс энэ Гашуун сухайтаар нүүрс гаргах нь бусад боомтоос гарахаасаа илүү ашигтай гэж үзэж байна уу. Эсвэл үүгээр гаргасан нь арай хямдаар гарна гэж үзэж байгаа юу. Тэгэхээр 20 сая тонноос бууруулахгүй гэдэг чинь ер нь яг юу гэсэн үг юм бэ. Энэ 2-ыг хариулаад өгчих. Тэгээд түүний дараа би санал хураалгах гээд байгаа юм.

**Р.Сэддорж:** Хариулт Дэлгэрсайхан сайд.

**Б.Дэлгэрсайхан:** Алдаржавхлан гишүүний асуултад хариулъя. Тэгээд энэ 27 сая тонн гэдгийг бол урд хөршийн биш, бид нарын санал юм байгаа юм гэж бас ойлгох хэрэгтэй. 1 дүгээрт бол хил холболтын ажил ингээд эхэлчихнэ энэ хавар. Хэрвээ одоо Улсын Их Хурлаар шийдвэр гараад, чиглэл гараад ингээд энэ гэрээ маань соёрхон батлагдчихвал ажил маань ингээд энэ хавраас эхэлчихнэ. Тэгэхээр 27 сая тонн гэдгийг бид яагаад тавьж байгаа юм гэхээр уурхайн хүчин чадалдаа тааруулж тавьж байгаа юм. Ухаандаа бид нарын өнөөдрийн олборлож байгаа хүчин чадал дээрээ бид нар үндсэндээ энэ Эрдэнэс Тавантолгойн удирдлагууд, инженерүүдтэйгээ ярилцаад бид нар дээрээс нь хэдийг яг олборлож энэ чадлаараа чадах юм бэ. Энэ ажлыг эхлүүлэхэд айлд бас нэг нүүрсээ гаргаж байх үүрэгтэй шүү дээ. Тийм учраас бид бол хоорондоо ярьж байгаад өдий хэмжээний л одоо өгч чадах юм байна гэдгээ л тоогоо тавьж байгаа л асуудал болохоос биш, урд хөрш яг төдийг авна гэж өөрсдөө зааж байгаа юм бас биш шүү гэдгийг бас та бүгдэд зориуд хэлье гэж бодож байгаа юм.

Энэ 5 жилийн хугацаанд бид юу хийх гэж байгаа юм гэхээр нөгөө шинээр олборлолт хийх, тэр шинээр олборлолт хийхийгээ бид нар бол бэлэн байгаа юм шиг бодоод байгаа юм. Яг амьдрал дээр бол тэр маань нөгөө хайгуулаа хийнэ, нөөцөө тогтооно, тэгээд яг одоо тэр нь олборлоход үр ашигтай байх уу, үгүй юу, хөрс хуулалт хэд байх вэ энэ тэр гээд наана нь хийх ажил маш их байгаа учраас ийм хугацаа авч, энэ хугацаандаа таарсан өөрсдийнхөө боломжид таарсан нүүрсээ гаргаж байгаа юм гэдгийг бол хэлье гэж бодож байгаа юм. Зөв биз.

2 дугаарт бол 30 тонноос 20 сая тонноос бууруулахгүйгээр гэдэг маань бол ер нь цаашдаа нүүрсний экспорт зүгээр хумигдаж магадгүй. Одоо энэ БНХАУ-д нүүрс нийлүүлдэг маш олон улсууд байдаг. Тэгээд бид бол тэдний л нэг өрсөлдөгч учраас аль болохоор өөрсдийнх нь боломжит хэлсэн хэмжээнд нь хүргэж гаргавал манайд ашигтай юм гэдэг талаас нь харсан болохоос биш, зүгээр урд айл бас та нар тэдээр бууруулж болохгүй шүү гэж бид нарт ямар нэгэн тулгалт хийсэн юм бол



байхгүй. Ер нь аль болохоор бас илүү гаргавал манайд ашигтай. Тэр үед нөхцөл байдал ямар байхыг өнөөдөр хэн ч тааж мэдэхгүй. Яг ний нуугүй хэлэхэд. Тэгээд магадгүй үнэ сайн байвал бид нарт ашигтай. Тэгэхдээ үнэ унахыг бас үгүйсгэ, бас аль алиныг урьдчилан таах, өнөөдөр 5 жилийн дараа .../минут дуусав/

**Р.Сэддорж:** Хариулт 4 номер.

**С.Жавхланбаатар:** Алдаржавхлан гишүүний асуултад хариулъя. Маш энгийнээр эхний 5 жил бол дээд босго гэсэн үг 27 сая. 27 саяас хэтрүүлж бол өгөх албагүй. Мэдээж өөр зарчмаар бол авч болно. Бид нарын зарчмаар бол эхний 5 жилд 27 сая. Сая Дэлгэрсайхан сайд хэллээ. Уурхайн хүчин чадалтайгаа олборлолтын хүчин чадалтай хамааруулаад өгч болох манай дээд хэмжээ гэсэн үг. 20 сая бол минимум хэмжээ зааж байгаа. Энэ нь бол сая манай талын бас ашиг сонирхолтой холбоотой. Яагаад гэвэл төмөр зам өөрөө хүчин чадлаараа бүрэн ажиллах ёстой л гэж шахаж байгаа юм. Дээр нь нөгөө шинэ олборлож орж байгаа шинэ ам нээж байгаа юуг одоо бас үр ашигтай олборлох ёстой. Төмөр замаа дүүрэн ачаатай байлгах л ийм л агуулга гэж ойлгож болно.

**Р.Сэддорж:** Алдаржавхлан гишүүн тодруулъя.

**Ж.Алдаржавхлан:** Би нэг ийм юм асуугаад байгаа шүү. Та хэд мэргэжлийн хувьд хэлээд өгөөч. Гашуунсухайтын боомтоор гарах нүүрс чинь манай бусад боомтоос гарах нүүрснээс арай хямд байх юм байна гэж би ойлгоод байгаа байхгүй юу. Тэгэхээр одоо энэ 20 сая тонноос их байх тусмаа Гашуунсухайт руу гарах нь хэрэгтэй юм уу. Эсвэл одоо бусад боомтоороо их гарах нь хэрэгтэй юм уу гээд би энэ 2-ын ялгааг л асуугаад байгаа юм.

**Р.Сэддорж:** 4 номер хариулъя.

**С.Жавхланбаатар:** Боомтын хямд, үнэтэй гэдэг нь тэрийг бол энэ чинь өөрөө нөгөө тухайн орд хилээс ямар зайд байгаа вэ гэдэгтэй холбоотой үнэ бол тээврийн зардалтай холбоотой хэлбэлзэж байгаа. Дээр нь бол бид нар бүх боомтоороо хүчин чадалд нь тултал нь л ачаа тээврээ гаргахыг л зорьж байгаа гэдгийг хэлэх хэрэгтэй.

**Р.Сэддорж:** Дэлгэрсайхан сайд нэмж хариулъя.

**Б.Дэлгэрсайхан:** Энэ манай зарим гишүүдийн хувьд бол Гашуунсухайт боомтоор хил гарвал хямд гараад байгаа юм. Энийг хаах ёстой. Бусдаар нь гаргах ёстой гээд буруу ойлгоод байгаа юм. Ер нь бол хамгийн дөт гарц буюу Гашуунсухайт боомтоор л хамгийн сайн гарах ёстой. Тэрнээс биш ингээд яах вэ үнэхээр бид илүү ихийг гаргах гээд бусад боомтоор гаргах ёстой л гэж ярьж байгаа юм. Энэ нь мэдээж Монголын хувьд бол ач холбогдолтой юу гэвэл ач холбогдолтой бас ашигтай. Тэгэхдээ бусад боомт руу явах замын урт бас ингээд үнэ ханш гээд ингээд олон юмыг тооцоход бол бас их төвөгтэй. Ингээд харьцангуй л асуудал л даа. Тийм учраас энэ дээр их зөв ойлгоорой. Энэ боомт нь өөрөө уг нүүрсэндээ илүү дөт ойрхон учраас аль алиных нь эрх ашигт нийцэж байгаа хугацааны хувьд ч эргэлтийн хувьд ч гэсэн тийм ач холбогдолтой юм шүү гэдгийг бас ойлгоорой гэдгийг энд давтан хэлье. Баярлалаа.

**Р.Сэддорж:** Дараагийн гишүүн Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн.

**Д.Энхтүвшин:** 4 асуулт байна. Тогтоолын төсөлтэй холбоотой. Тогтоолын төслийн 2, 5 дээр болохоор Гашуун сухайт-Ганц мод чиглэлийн төмөр замын эдийн засгийн үр өгөөжийг хангах зорилгоор энэ нүүрс худалдаж, худалдан авах гэрээг байгуулна гэсэн байгаа. Тэгэхээр энэ үр өгөөж гэдэг маань томъёолол нь бас жишээлбэл хэмнэлтээрээ бодоод үзвэл 10 долларын зөрүүтэй гэж бодоход энэ ашиг гэж бодвол 30 сая тонн гэвэл 300 сая доллар. Жишээлбэл ингээд хөрөнгө оруулалтын өгөөжөө нөхөх, маш хурдан нөхчих бололцоотой. Тэгэхээр яагаад одоо жишээлбэл нөхчихвөл энэ 16 жил гэдэг юу чинь бас энэ зорилготой нийцүүлнэ гэвэл нийцэхгүй юм шиг, түрүүлээд гэрээгээ дуусгаж магадгүй юм шиг ийм санаа энд яваад байна л даа. Энийг зүгээр өөрөөр томъёолох боломж байдаг юм болов уу. Эсвэл энийг давхар өөр бодолтой хийсэн үү гэж 1 дүгээр асуулт.

2 дугаарт нь болохоор Ганц мод-Гашуун сухайттай холбоотой энэ төмөр зам дээр болохоор нөгөө талын одоо жишээлбэл Хятадын тал төмөр замаа тавьчихсан учраас бид нар биелүүлээгүй. Энэ хил холболт дээр тэгэхээр нөгөө талд энд холбохын тулд бид нар нүүрсний гэрээ хийж байгаа гэсэн логик Ганц мод-Гашуун сухайт боомт дээр явж байгаа юм. Тэгэнгүүт бусад боомтууд дээр бас яг үүнтэй адилхан логик явах юм биш биз дээ. Өөрөө хэлбэл Сэхээ боомт дээр, Мандуулай боомт дээр одоо нөгөө талд Хятадууд бас төмөр замаа барьчихсан гэдэг асуудал ярих вий дээ. Тэгэхээр энэ 9 дээр жишээлбэл ийм юм тооцохгүй гэдэг дээр ийм санаа оруулах ёстой юу үгүй юу. Энэ талаар бас санаа бодлыг нь сонсьё. Мэдээж яах вэ Хятадад бол 2 төрлийн төмөр зам байгаа. Төмөр замын яамны төмөр зам, Шинхуагийн төмөр зам гээд. Тэгээд яах вэ, ТӨК-ийнх дээр нь болохоор ингэж байна уу энэ дээр хэрвээ шаардлагатай гэвэл 9 дээр тийм заалт нэмэх үү, үгүй юу гэдэг нэг асуулт байна.

3 дугаарт нь энэ нүүрс борлуулалттай холбоотой асуудлуудаа яг Чайна энерги маань болохоор коксжих нүүрсний зах зээл дээр бол бас жижиг тоглогч. Өөрөөр хэлбэл гангийн үйлдвэр, кокс химийн цөөн үйлдвэрүүдтэй. Тэгэхээр эрчим хүчний голдуу үйлдвэр байгаа. Тэгэхээр өөрөөр хэлбэл эд нар Хятадын зах зээл дээр бол худалдаа хийнэ гэсэн үг. Гангийн үйлдвэрүүдэд болон бусад кокс химийн үйлдвэрүүдэд өгнө. Тэгэхээр Шинхуагийн хувьд бол Хуанхуа Порт руу өөрсдөө өөрөөр хэлбэл далайн эрэг рүү нүүрс аваачих capacity-тэй. Төмөр замын чадалтай. Тэгэхээр хэрвээ ингээд чөлөөтэй хаячихвал бид нар их экспортлох тусмаа манай нүүрснүүд хоорондоо өрсөлдөх учраас эд нар төмөр замын ийм давуу талтай учраас тодорхой хэмжээнд жишээлбэл яг тэр Хуанхуа Порт далайн эрэг орчимд аваачиж зарна гэсэн тийм санааг энэ жишиг үнээсээ гадна бас энэ 4 дүгээр заалт дээр оруулах тийм боломж байдаг юм болов уу.

Дөрөвдүгээрт нь болохоор энэ 11 дээр эрчим хүчний нүүрс экспортлох гэж байгаа. Тэгэхээр бусад 4 болон 5 дугаар заалт дээр нүүрс худалдаж, худалдан авах гэрээ гэж байгаа. Өөрөөр хэлбэл энэ дотор коксжих нүүрс гэдэг үг байхгүй байгаа. Тэгэхээр уг нь бол энэ эрчим хүчний нүүрс чинь бол яваандаа бол бидний хамгийн том асуудал болно. Төмөр зам ороход хамгийн эхэнд бид нарын давуу тал олох юм чинь эрчим хүчний нүүрс. Тэр эрчим хүчний нүүрс чинь .../минут дуусав/

**Р.Сэддорж:** Нэмж 1 минут өгье.

**Д.Энхтүвшин:** Тэгээд эрчим хүчний нүүрс маань энэ овоолго үүсээд байхаар өөрөө ингээд шатдаг. Тэгэхээр өөр тэр орчимд хийсэн энэ их хэмжээний

олборлолт хийгээд бид нар эрчим хүчний нүүрснийхээ асуудлаа шийдэхгүй бол бусад олборлолтод нөлөөлнө. Тэгэхээр уг нь энэ тусад нь эрчим хүчний нүүрс гэж 11 дүгээр заалт дээр оруулахын оронд энэ нүүрс гэдэг 4 болон 5 дээр байгаа нүүрс худалдаж, худалдан авах гэрээ гэдэг дотроо коксжих нүүрс, тэгээд 3-ны 1 нүүрс, тэгээд энэ эрчим хүчний нүүрсээ ойлгоно гэж ойлгоод энэ дотроо оруулаад явчихвал уг нь зүгээр юм шиг санагдаж байна. Тэгэхгүй бол ер нь бол коксжих нүүрсээ ч гэсэн бид нар хангалттай хэмжээнд экспортолж чадахгүй хэмжээнд хүрэх ийм 4 асуулт.

**Р.Сэддорж:** Хариулт. Дэлгэрсайхан сайд.

**Б.Дэлгэрсайхан:** Энхтүвшин гишүүний асуултад хариулъя. Ер нь бол манай Энхтүвшин гишүүн бол энэ нүүрс, нүүрсний экспортын талаар бол бусад гишүүдээс илүү сайн ойлголттой, бас мэдээлэлтэй гэж би ойлгодог. Тэгэхээр зэрэг энэ нөгөө өөрийн чинь хэлж байгаа эдийн засгийн үр өгөөжийг хангах зорилгоор гэдэг дээр та хүчин чадал, эдийн засгийн үр өгөөжийг хангах зорилгоор гэдэг дээр ач холбогдол өгч байх шиг байна. Тэгэхээр бид нар нэгэнт ийм их мөнгө зарж төмөр зам тавьсан учраас төмөр замынхаа тээврийн хүчин чадал, эдийн засгийн үр өгөөжөө л хангах гэдэг дээр ойлгоорой гэж 1 дүгээрт хэлье.

Түрүүн манай Жавхланбаатар хэлсэн. Одоо бид нар тэр төмөр замаа 100 хувь ингээд 20 саяд нь хүргэж хүчин чадлаар нь ашиглахын тулд ингэж оруулсан шүү гэж хариулсан. Тэр бол бас ингээд давхар хариулт болж байгаа гэдгийг хэлье.

2 дугаарт бол “Чайна Энержи” компани өөрөө эрчим хүчний компани учраас бид энэ доод талын 11 дүгээр зүйлд тусад нь зааж өгч байгаа нь цаашдаа бол бид нар ингээд энэ дандаа коксожсон нүүрс биш, ер нь цаашдаа эрчим хүчний нүүрсний экспорт дээр бас хамтарч ажиллана гэдэг үгийг тусад нь зориуд оруулж байгаа юм. Яагаад гэвэл энэ бол өөрөө “Чайна Энержи” бол үндсэн үйл ажиллагаа явуулдаг юу нь бол эрчим хүчний компани шүү дээ. Одоо Хятадын эрчим хүчээр хангах, тэгээд өөрөө олон станцуудтай, цахилгаан станцуудтай ийм компани.

Дараагийн дугаарт бол төмөр зам дээр давуу тал, давуу эрх эдлээд ингээд нүүрс ачаад, цаашаа Хуанхуа боомт дээр аваачаад ингээд илүү их ашиг олох юм биш биз гэдэг ийм асуулт асууж байна. Энэ дээр бол ийм юм байхгүй. Энэ төмөр зам холбох гэрээг Зам, тээврийн яам хийнэ. Энэ дээр бид нар энэ гэрээг одоогийн байдлаар бол ингээд нэлээн дөхүүлчихсэн байгаа. Энэ гэрээн дээрээ бол аль аль тал нь давуу эрх эдлэхгүй. Адил тэнцүү, тэгш эрхээр тээвэр хийнэ гэдгийг оруулсан байгаа. Тийм учраас энэ 2 Засгийн газар хооронд хийж байгаа энэ гэрээн дээр ийм жижиг асуудлыг одоо оруулаад яах вэ гэж бодож ингэж хийсэн шүү гэдгийг хэлье. Баярлалаа.

**Р.Сэддорж:** 4 номер нэмж хариулъя.

**С.Жавхланбаатар:** Энхтүвшин гишүүний асуултад хариулъя. Ер нь бол анхны 2022 онд хэлэлцээ хийж байхад бол зөвхөн коксжих нүүрс авна гэж нөгөө тал маань ярьж байсан юм байна лээ. Протоколд нь байсан. Одоо бидний яриа хэлэлцээнд бол энэ чинь нөгөө Засгийн газар хоорондын хэлэлцээр маань батлагдах явцад бид нар ТӨК-уд хооронд байгуулах 3 гэрээгээ бас давхар байгуулна. Нүүрс худалдах, худалдан авах гэрээ дотор бол коксжих, 3-ны 1 коксжих, эрчим хүчний нүүрсний харьцааг тохирч оруулж ирэх юм. Тэр гэрээн

дээрээ нарийвчилж тохирч оруулж ирнэ. Ерөнхийдөө айлын тал аль алийг нь авна гэдэг зөвшилцөлд бол хүрсэн. Өчигдөр, уржигдар бид нар бас Хятадын талтай хэлэлцээ хийсэн. Улаанбаатарт хийсэн. Энэ үеэр бол бид нар эрчим хүчний нүүрс худалдан авах хэмжээгээ нэлээдгүй нэмэгдүүлэх боломжтой гэдгээ болбол айлын тал илэрхийлсэн байгаа. Баярлалаа.

**Р.Сэддорж:** Энхтүвшин гишүүн тодруулъя. 1 минут.

**Д.Энхтүвшин:** Бусад боомтууд дээр Ганц мод Гашуун сухайттай холбоотой адилхан одоо жишээлбэл нүүрсний гэрээ хийнэ. Одоо Сэхээ юу, Шивээ хүрэн Сэхээ дээр ч гэдэг юм уу Ханги мандал дээр ч юм уу ийм асуудал үүсэхгүй байгаа. Тэгээд тэрийгээ жишээлбэл энэ дээр одоо заалт оруулчихсан байгаа шүү дээ 19 дээр энэ дээрээ нэмж оруулах хэрэг байна уу, үгүй юу гэсэн нэг тийм асуулт байсан тэр дээр.

**Р.Сэддорж:** Хэн хариулах вэ. Дэлгэрсайхан сайд.

**Б.Дэлгэрсайхан:** Ер нь бол бид нарын ганц зорилго бол Гашуун сухайт боомт биш, Ганц мод-Гашуун сухайт биш. Ер нь бүх боомтуудаа л холбоё гэдэг ийм зорилготой байгаа. Тэгэхээр зэрэг нэгэнт энэ гэрээ маань бол Гашуун сухайт-Ганц мод гэдэг боомт дээр одоо голлож хийгдэж байгаа учраас цаашдаа Хятадын талын өөрийнх нь анх ярьж байсан анхны Гашуун сухайт-Ганц модны боомтыг холбосны дараа бусад боомтуудыг шат дараатай холбоно гэдэг энэ үгийг нь бид нар баталгаажуулах үүднээс энэ гэрээндээ зориуд оруулж өгч байгаа юм. Энэ нь тэгж байж өөрөөр хэлбэл ганц Гашуун сухайт-Ганц мод гээд орхичихлоор зэрэг бусад боомтоо дараа нь одоо бас өөр юм ярьж магадгүй гэж байгаа учраас нэгэнт Засгийн газар хоорондын гэрээн дээр үргэлжлүүлээд, үүний бүтээн байгуулалтын ажил эхлэнгүүт бусад боомтуудаа бид нар өөрөөр хэлбэл Шивээ хүрэн, Сэхээ, Хангимандал, Бичигт, Зүүн Хатавч боомтуудаа холбох ажлыг үе шаттайгаар эхлүүлнэ гэдэг юмаа оруулж өгч байгаа нь илүү ач холбогдолтой гэж үзэж байгаа юм. Тийм юм бол байхгүй. Тийм юм байхгүй. Тийм юм бол энэ боомтууд дээр бол ямар нэгэн тийм юу байхгүй. Өөрөөр хэлбэл юу гэдэг юм юу гэж хэлбэл оновчтой юм бэ дээ. Тийм янз бүрийн шантааж байхгүй л гэсэн санаа. Байхгүй. Зөв зөв.

**Р.Сэддорж:** Нэмж хариулах юм уу. 1 номер.

**Б.Артур:** Энхтүвшин гишүүний асуултад хариулъя. Хуанхуа боомт хүртэл бол тээвэрлэж болох нөхцөл бол байгаа. Өнөөдрийн байдлаар бол энэ зөвхөн хил дамнасан байгууламжаа байгуулах талаар бол Хятадын аж ахуйн нэгжтэй бол ярилцаж байгаа. Гэрээ байгуулах асуудал байгаа. Хятадын талтай яг өнөөдрийн байдлаар тээвэрлүүлэх нөхцөлд бол Хятад хүлээн авагчтай Хятад аж ахуйн нэгжийн нэрийн өмнөөс бол Хуанхуа боомт бол тээвэрлэх бол боломжтой. Өнөөдөр энэ боомт нь 2 талын шинжтэй боомт байгаа.

**Р.Сэддорж:** Өөр хариулт нэмэх юм байна уу. Гишүүд асуулт асууж дууслаа. За тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналуудаар санал хураалт явуулна.

1 дүгээрт Жаргалан гишүүний гаргасан санал байна.

Төслийн 1 дэх хэсгийн 2 дугаар заалтад “гурван асуудлыг харилцан уялдаатай цогц байдлаар хамтад нь шийдвэрлэх” гэснийг “арга хэмжээг уялдуулан шийдвэрлэх” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Жаргалан саналаа тайлбарлая. Жаргалан гишүүн.

**Б.Жаргалан:** Би найруулгын шинж чанартай нэлээн хэдэн зарчмын зөрүүтэй санал гаргачихсан байгаад байгаа юм. Тэгэхээр нөгөө орой болчихсон цаг хугацаанд бас та хэдийгээ бас чилээх нь байна. Энэ 1 дүгээр хэсгийн 2 дугаар заалт дээр энэ “гурван асуудлыг харилцан уялдаатай цогц байдлаар шийдвэрлэх” гээд нөгөө Хятадын талаас ирсэн нэг захидал дээр “гурвыг цогцоор” гэдэг нэг ийм нэр томьёо дурдагдаад байсан шүү дээ. Тэгэхээр тэр нэр томьёоноос би бол зайлсхийх нь зүйтэй гэж харж байгаа. Яагаад вэ гэхээр тэртээ тэргүй тэр 3 асуудлыг нь цогцоор нь уялдуулаад энэ тогтоол дээр шийдэж байгаа. Тэгэхээр ажлын хэсэг энэ дээр найруулга дээр бол жоохон хариуцлага муутай л ажиллаж дээ. Тэгээд Их Хурал дээр ийм юм яриулаад. Энэ чинь Их Хурал нь засагтаа чиглэл өгч байгаа шүү дээ. Тийм биз дээ. Тэгэхээр бид нар энэ найруулгуудаа бас жоохон засаж залруулах нь зүйтэй гэсэн бодлоор ийм зүйл ярих гэсэн юм. Тэртээ тэргүй тэр 3 асуудал нь цогцоороо энд ороод ирчихсэн байж байгаа. Тэгэхээр тэр гурвыг цогцоор гэдэг тэр юунаас нь зайлсхийж байгаа ийм санал шүү. Тэгээд цаашаа бас хэд хэдэн санал байгаа. Тэгээд бүгдийг нь тухай бүрд нь тайлбарлаад явъя.

**Р.Сэддорж:** Тогтоолын төслийн 1 дэх хэсгийн 2 дугаар заалт “гурван асуудлыг харилцан уялдаатай цогц байдлаар хамтран шийдвэрлэх” гэснийг хасаж, “арга хэмжээг уялдуулан шийдвэрлэх” гэж өөрчлөх. Гишүүд саналаа өөрсдийнхөө итгэл үнэмшлээр Байнгын хорооны санал хураалтад өгнө. Ингээд санал хураалт. 14,3 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй. Жаргалан гишүүнийг дэмжсэнээр протоколд тэмдэглэе.

2.Тогтоолын төслийн 1 дэх хэсгийн 3 дахь заалтад “хамтын ажиллагаанд “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцаа, эзэмшиж байгаа ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг бусад этгээдэд шилжүүлэхгүй байх” гэснийг хасаж, “ажлыг Эрдэнэс Тавантолгой” ХК хариуцан зохион байгуулах хүрээнд оператор аж ахуйн нэгжийг нээлттэй сонгон шалгаруулах” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Жаргалан. Саналаа тайлбарлая Жаргалан гишүүн.

**Б.Жаргалан:** Энэ болохлоор яаж байна вэ гэхээр сая Дэлгэрсайхан сайдаас асуусан. Яагаад ийм “Эрдэнэс Тавантолгой-гийн хувьцааны эзэмшлийг нөгөө Хятадын талтай байгуулах гэрээ дээр яриад унасан юм бэ гэсэн чинь үгүй ээ үгүй цаадуул чинь бол бид нар хувь эзэмшинэ гэсэн санал тавьсан. Тэрнээсээ буцчихсан гэж хэлж байгаа. Тэрийгээ баталгаажуулж байгаа юм гэсэн санааг хэлж байгаа. Тэгэхээр энэ дээр юу гэж найруулж байна вэ гэхээр Монгол, Хятадын хилийн Гашуун сухайт-Ганц мод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын хүрээнд уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх ажлыг Эрдэнэс Тавантолгой ХК хариуцан зохион байгуулах хүрээнд оператор аж ахуйн нэгжийг нээлттэй сонгон шалгаруулах гээд зүгээр “Эрдэнэс Тавантолгой” байдгаараа байгаад, энэ бүх шийдвэрүүдээ гаргана гэсэн байдлаар найруулж байгаа ийм найруулгын санал байгаа шүү. Тэгэхгүй бол бид нар Засгийн газар хоорондын гэрээ байгуулж байж, дотоодынхоо хувьд үндэсний ийм төрийн өмчит компанийн хувьцаа эзэмшлийг оролдохгүй шүү энэ тэр гэсэн ийм зүйл бас оруулаад байж болохгүй гэсэн санаа.

**Р.Сэддорж:** Саяын томьёоллоор санал хураалт. 19 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй. Батчимэг гишүүн, Цэнгүүн гишүүн нарыг дэмжсэнээр протоколд тэмдэглэе. Төхөөрөмж ажиллахгүй байна.

3.Тогтоолын төслийн 1 дэх хэсгийн 4 дүгээр заалт “тогтоохдоо” гэсний дараа “зах зээлийн үнийг харгалзан” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Жаргалан. Жаргалан гишүүн.

**Б.Жаргалан:** Бүтнээр нь уншиж өгье. Гашуун сухайт-Ганц мод чиглэлийн төмөр замын тээврийн багтаамж, эдийн засгийн үр өгөөжийг хангах зорилгоор нүүрс худалдах, худалдан авах урт хугацааны гэрээний үнийг тогтоохдоо “зах зээлийн үнийг харгалзан гээд шинээр оруулж байгаа хэсэг” зах зээлийн үнийг харгалзан “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн урт хугацаатай байгуулсан гэрээний нөхцөл, үнийн аргачлалыг жишиг болгож, гэрээний хугацааг хэлэлцээ хийж эхэлсэн хугацаатай уялдуулан 16 хүртэл жилээр тогтоох.

Тэгэхээр яах вэ, энэ дээр зүгээр ерөнхийдөө бол бүр дискаунт хэт өндөр байж болохгүй л гэсэн тийм санааг ийм тойруу байдлаар оруулж өгч байгаа гэсэн л санаа. Тэгэхгүй дискаунт чинь хэд хэд байгаад байгаа нь бас ойлгомжгүй байгаад байна шүү дээ. Тийм биз дээ. Тэгэхээр яах вэ, зүгээр л протокол тэмдэглүүлээд, энэ дискаунт ерөөсөө тийм бас хэт өндөр байж болохгүй. Зах зээлийн үнээс бол хэтэрхий доошоо байж болохгүй гэсэн санааг л оруулахыг хүсээд байгаа юм.

**Р.Сэддорж:** За саяын томьёоллоор “тогтоохдоо” гэсний араас “зах зээлийн үнийг харгалзан” гэж нэмэх гэсэн томьёоллоор санал хураалт. 38,1 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Дугаарлалтаараа явж байгаа.

4.Тогтоолын төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалтын “16 хүртэл жилээр тогтоох” гэсний дараа “нүүрсийг “Ганц мод” боомт нөхцөлөөр нийлүүлэх, тээврийг Монголын тал хариуцан гүйцэтгэх агуулгаар тохиролцох” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Золжаргал. Тайлбарлая. Золжаргал гишүүн.

**Ж.Золжаргал:** Би Монгол нүүрс ассоциацийн гүйцэтгэх захирлаар сүүлийн хэдэн жил ажилласан. Бараг улирал болгон Хятадын янз бүрийн нүүрсний худалдааны тээврийн хурал, зөвлөгөөнүүдэд Хятадын болон олон улсын юунд очиж байсан. Мэдээлэл бол байгаа. Түрүүчийн ажлын хэсэг нь уг нь хил нөхцөлөөр гэж ярьж байсан юм байна лээ. Тэгээд тэр нь юугаараа давуу талтай гэхээр 1 дүгээрт мэдээж тэр тээврийн ашиг, үйл ажиллагааг Монголын талынхан илүү их хийнэ. Тэр авто тээвэр байна уу, төмөр зам байна уу. Хамаагүй. Ашиг нь наанаа үлдэнэ гэсэн үг. Үнэ өртгийг бол хаа хамаагүй нэмж чадахгүй. Олон улсын хэлэлцээрүүд байдаг. Монгол Улс, БНХАУ-ын аль аль нь орчихсон. Замын эвдрэл, гэмтэл, орон нутгийн бослого хөдөлгөөн, зам хаах энэ үйлдлүүдийг бол Хятадын тал манеж хийж чадахгүй, манай тал л хийнэ. Тийм болохоор хил нөхцөлөөр хүргэж өгөөд, хуучин ярьж байсан энэ юугаа үргэлжлүүлэе гэдэг асуудлыг тавиач гэсэн ийм санаа юм. Баярлалаа.

**Р.Сэддорж:** Золжаргал гишүүний гаргасан “16 он хүртэл жилээр тогтоох” гэсний дараа “нүүрсийг ганц мод нөхцөлөөр нийлүүлэх, тээврийг Монголын тал

хариуцан гүйцэтгэх агуулгаар тохиролцох” гэж нэмэх гэсэн саналын томъёоллоор санал хураалт. 19 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Энхтүвшин гишүүн, Найдалаа гишүүн нарыг дэмжсэнээр протоколд тэмдэглэе.

5.Тогтоолын төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалт “жишиг болгож” гэснийг “зах зээлийн өнөөгийн нөхцөлд нийцүүлэн өөрчилж, суурь үнийг шинэчилж, үнийн индексийг Бүгд Найрамдах Хятад Ард Улсын болон олон улсын зах зээл дээрх үнийн мэдээлэл, Монголын хөрөнгийн биржээр худалдаалсан нүүрсний үнийн мэдээллийг ашиглан тооцоолох” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Золжаргал. Саналаа тайлбарлая Золжаргал гишүүн.

**Ж.Золжаргал:** Одоогийн байгуулагдсан гэрээнүүдийг жишиг болгож гэж байгаа. Өнгөрсөн сарын дүнгээр бол 75, 76 доллар уурхайн аман дээр, тэр үед биржийн үнэ 135 доллар байсан. Тэр уурхайгаас Хятадын тал хил хүртэл тээвэрлэдэг нь ойролцоогоор 30 доллар. Монголын компаниуд бол 15-20 доллароор тээвэрлэдэг. Ингээд нийлбэр дүн нь бол 105, 135, 30 долларын зөрүүтэйгээр 10 сая тонн нүүрс гээд бодох юм бол 300 сая доллар болно гэх мэтчилэн. Гэхдээ биржийн үнэ бол мэдээж эрэлтээсээ хамаарна. Зарим тохиолдолд онцгой унана. Зарим тохиолдолд энэ зөрүү нь бараг байхгүй болно. Заримдаа манайд ашигтай болохыг бол ойлгож байгаа. Гэхдээ тэр үнэ бол суурь үнэ болон 5 индексээс бүрдэж байгаа. Хятадын 5 индекс дээр нэмэх нь нэгэнт энэ ажиллалчигсан биржийнхээ индексийг нэмье. Дээрээс нь аль нэг томоохон гаднын улсын индексийг нэмье. Ингээд 3 субъектийн харилцан тэнцвэртэйгээр оруулах юм бол би бол яагаад Хятадын тал үүнээс татгалзах гэдэг юуг бол харахгүй байгаа. Энэ бол хүлээж авах боломжтой бөгөөд тийм бодитой л гэж үзэж байгаа. Тэгээд та бүхэн энийг бодолцоно биз дээ. Энэ үнийн зөрүү бол ер нь олон их наядаар яригдах зөрүү байгаа шүү.

**Р.Сэддорж:** Нэмж асуулт, хариулт байхгүй учраас шууд санал хураалтууд үргэлжилнэ. Ингээд Золжаргал гишүүний гаргасан саяын саналын томъёоллоор санал хураалт. 38,1 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

6.Тогтоолын төслийн 1 дэх хэсэгт шинэ дэд заалт нэмэх тогтоолын төслийн нэг дэх хэсгийн 5 дахь дэд заалтыг өөрчлөн найруулах. Нэг тогтоолын төслийн нэг дэх хэсэгт дараах дэд заалт нэмэх 12 Монгол Улсын тэргүүлэх чиглэлийн 14 мега төслийн Хэрлэн тонн ус дамжуулах шугам хоолой татах бүтээн байгуулалтын ажлыг хамтран гүйцэтгэх гэрээ хэлцлийг 2025 оноос эхлэхээр зохион байгуулалтын арга хэмжээ авах. 1 дүгээр Очирбат гишүүн Улсын Их Хурлын гишүүн санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Очирбат. Очирбат гишүүн байхгүй байна уу. Очирбат гишүүн тайлбарлая. Очирбат гишүүний микрофоныг нээе.

**Г.Очирбат:** Бүгдэд нь оройн мэнд хүргэе. Бид нар 2024-2028 оны үйл ажиллагааныхаа хөтөлбөрийг бас баталсан. Энэ дээр бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал бас давхар явж байгаа. Ялангуяа говийн бүсэд бол аж үйлдвэрийг тэргүүлэх чиглэлтэй ногоон эрчим хүчний дэд тэргүүлэх чиглэлтэй бүс болгосон. Говиос сонгогдсон гишүүд болон бас зарим гишүүд яг говийн нөхцөл байдлыг бол ойлгож байгаа. Яг өнөөдрийн нөхцөл байдал бол үнэхээр хүнд байгаа. Би бол түрүүн Боомтын сайдтай бас ажиллаад ирсэн. Мөн дээрээс нь говиос сонгогдсон

гишүүд Оюутолгойн болон Тавантолгойн бас Улсын Их Хурлын гишүүдэд үйл ажиллагаа танилцуулах процесст нь оролцоод ирсэн. Тэгээд очиход бол тэнд яг усны асуудал үнэхээр тулгамдчихсан байгаа. Бид тэнчээ аж үйлдвэрийн парк барих гээд байдаг ус байдаггүй. Боомтдоо Хятадын хөрөнгө оруулалтаар манай бас дотоодын хөрөнгө оруулалтаар боомтын сэргээн босголтынхоо ажлуудыг хийчихсэн байдаг. Очоод гар угаах гэхээр ус байдаггүй. Аж үйлдвэрлэгч нартай очоод уулзахаар усны асуудал үнэхээр хүндэрчихсэн гэдэг. Тэгэхээр яг энэ төмөр замтай холбоотой энэ Их Хурлын тогтоол гаргах гэж байгаа тэр чиглэл болгоод 2025 оноос эхлүүлээд Хэрлэн Тооно ус татах энэ төслөө бас давхар ингээд чиглэл болгоод оруулаад өгчихвөл бас магадгүй Монгол Улсын бас дараагийн аж үйлдвэрийн салбарт нэлээн дэм болох болов уу гэж бодож байгаа юм. Тэгээд манай Их Хурлын гишүүд Байнгын хорооны гишүүд та бүхэн энэ дээр бас нэлээн анхааралтай хандаж энэ 2024-2028 оны үйл ажиллагааны Засгийн газрын хөтөлбөр, мөн дээрээс нь энэ 14 мега төслийнхөө бас 1 төсөл нь эхэнд бичигдсэн Гашуун сухайт-Ганц мод, дээрээс нь 12-т бичигдсэн энэ Хэрлэн Тооно гэсэн 2 төсөл бас зэрэг явчих бүрэн бололцоо байгаад байгаа. Тэгээд нөхцөл байдал бол хүндийг нь ойлгож байгаа. Янз бүрийн байдлаар энийг өөрчилж болохгүй. Янз бүрийн байдлаар яг энэ нөхцөл байдал дээр яг энэ хугацаанд бол болохгүй гэсэн юмнууд явж байгааг нь ойлгож байгаа. Тэгээд энд байгаа манай Байнгын хорооны гишүүд аж үйлдвэржилтийнхээ бодлогыг 14 мега төслөө бодоод энэ саналыг бас дэмжиж өгөөсэй гэж хүсэж байгаа юм. Баярлалаа.

**Р.Сэддорж:** 14 мега төслийн 2 нь хоорондоо холбогдож байна гэсэн үг. Ингээд Очирбат гишүүний гаргасан, Тогтоолын төслийн 1 дэх хэсэгт дараах заалтыг нэмэх:

“12.Монгол Улсын тэргүүлэх чиглэлийн 14 мега төслийн “Хэрлэн тооно” ус дамжуулах шугам хоолой татах бүтээн байгуулалтын ажлыг хамтран гүйцэтгэх гэрээ, хэлцлийг 2025 оноос эхлэхээр зохион байгуулалтын арга хэмжээ авах” гэж шинэ заалт нэмэх саналаар санал хураалт. 23,8 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй. Батчимэг гишүүн төхөөрөмж ажиллаагүй дэмжсэнд протоколд тэмдэглэе.

7.Очирбат гишүүний гаргасан 2 дахь санал. Тогтоолын төслийн 1 дэх хэсгийн 5 дахь дэд заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“Гашуун сухайт-Ганц мод чиглэлийн төмөр замын тээврийн хүчин чадал, эдийн засгийн үр өгөөжийг хангах зорилгоор Нүүрс худалдах, худалдан авах гэрээний дагуу нийлүүлэх нүүрсний хэмжээг 2025-2029 онд нийт 27 сая тонн /үүнээс 7 сая тонн нь Эрдэнэс Тавантолгойн баяжуулах үйлдвэрээс гарч байгаа баяжуулсан нүүрс/, 2030 оноос эхлэн жилд 20 сая тонн /үүнээс 5 сая тонн нь баяжуулах үйлдвэрийн баяжуулсан нүүрс/-оос бууруулахгүй байх гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Г.Очирбат. Очирбат гишүүн тайлбар хэлье.

**Г.Очирбат:** Дахиад л “Эрдэнэс Тавантолгой” бол сүүлийн жилүүдэд энэ баяжуулах үйлдвэрүүд дээрээ нэлээн сайн ажилласан. “Эрдэнэс Тавантолгой”-оос 1 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалтаар бас энэ баяжуулах үйлдвэр маань боссон. 2025 оны 3 сард бүтэн үйл ажиллагаа явуулах бүрэн нөхцөл бололцоогоор хангагдсан байгаа. Тэгээд бид бол сүүлийн жилүүдэд дандаа түүхийгээр нь биш баяжуулж гаргая гэж ярьдаг. Тэгээд яг өнөөдөр “Эрдэнэс Тавантолгой” маань энэ



баяжуулах үйлдвэрээ ашиглалтад оруулчихсан, баяжуулах бүрэн бололцоотой болчихсон байгаа. Тэгэхээр бас энэ тогтоолын төсөл дээр чиглэл болгоод 2025 онд 5 сая гэж байвал 2025 онд 5 сая, 2026 онд 5 сая, 2027 онд 6 сая, 2028 онд 6 сая гэж байгаа юм. Үүнээс 1, 1 сая тонныг нь ядаж баяжуулсан нүүрсээ оруулчихвал гэсэн санаа юм.

2-т гэх юм бол 2030 оноос авхуулаад 20 сая тонныг бид нар өгөх. Энэ дээр бас баяжуулснаасаа 5 сая тонныг нь өгвөл ямар ч байсан дотооддоо манай 5 толгойнхныхны хийсэн ажлынх нь үр дүн 1 дүгээрт гарах ёстой. 2 дугаарт бид нар бас ингээд баяжуулаад, магадгүй дараа нь ингээд кокс химийнхээ үйлдвэрийг барих энэ сэдэл нь бас манай “Эрдэнэс Тавантолгой”-н энэ хамт олонд бас үүсэх юм болов уу гэж бодож байгаа. Тэгэхээр энэ дээр бас манай Их Хурлын гишүүд саналаа хураахдаа “Эрдэнэс Тавантолгой”-н хийсэн ажлыг нь бас бодоорой. 1 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалтаар баяжуулах үйлдвэр баригдчихсан байгаа. Тэгэхээр энэ баяжуулах үйлдвэрийнхээ бүтээгдэхүүнийг бас энэ Их Хурлын тогтоолын төсөл дээр чиглэл болгоод Засгийн газар луу оруулаад өгчихвөл зүгээр байгаа юм шүү. Тэгээд анхаарал хандуулсанд баярлалаа.

**Р.Сэддорж:** Очирбат гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй 2 дахь саналаар санал хураалт. 23,8 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

8.Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалтын “бууруулахгүй байх” гэсний өмнө “Монгол Улсаас Бүгд Найрамдах Хятад Ард Улсад нийлүүлэх нүүрсний нийт хэмжээг 120 сая тонноос багагүй хэмжээнд хүргэх тохиролцоо хийх” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргал. Золжаргал гишүүн тайлбарлая.

**Ж.Золжаргал:** Нийт нүүрсний хэмжээ 120 сая тонн хүрнэ гэж байгаа. Тэгээд энэ бол зүгээр манайхны тайлбар биш 2 улсын хооронд Засгийн газрын хооронд хэлэлцээр хийж байгаа бол зорилт тавих, тэрийгээ тусгах нь бол боломжтой гэж үзэж байна. Тэр тохиолдолд бол нүүрсний хямдралтай нүүрсний нийт их хэмжээний хямдралтай. Нүүрсний үнэ, Монголын нүүрсийг тэр чигээр нь унагаах сөрөг нөлөө бол багасна.

Нөгөө талдаа Монголын нийт экспорт ч бас урт хугацаандаа тогтвортой байх боломж бүрдэх юм болов уу гэж. Тэгээд боломжтой болбол нөгөө талдаа ийм санал тавиад явах нь зөв байх л гэж бодож байна. Улсын хэмжээнд, Монгол Улсын хэмжээнд.

**Р.Сэддорж:** Улсын Их Хурлын гишүүн Золжаргал гишүүний тогтоолын төслийн 5 дугаар зүйлийн 5 дахь заалтын “бууруулахгүй” гэсний өмнө “Монгол Улсаас БНХАУ-д нийлүүлэх нүүрсний нийт хэмжээг жилд 120 сая тонноос багагүй хэмжээнд хүргэх тохиролцоо хийх” гэж нэмэх гэсэн саналын томъёоллоор санал хураалт. 21-17 гишүүн танхимд байна. Гишүүд итгэл үнэмшлээрээ саналаа өгч байгаа гэдгийг энд бас дурдъя.

9.Тогтоолын төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалт “бууруулахгүй байх” гэсний дараа “, “Эрдэнэс Тавантолгой” компанийн уурхай олборлолтын төлөвлөгөөтэй нийцүүлэн коксжих, сул коксжих, эрчим хүчний нүүрсийг зохимжит хувь харьцаагаар нийлүүлэх буюу зөвхөн нэг төрлийн нүүрсийг сорчлохгүй байх”

гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Золжаргал. Золжаргал гишүүн тайлбарлая.

**Ж.Золжаргал:** Энэ ганцхан боомтын талаар ярьж байгаа гээд байх юм. Энэ 10 дугаар заалт дээр чинь эхлүүлснээр Шивээ хүрэн, Сэхээ, Ханги Мандал, Бичигт, Зүүн Хатавч зэргийг ингээд холбох ажилд үе шаттайгаар эхлүүлэх тохиролцоонд хүрэх.

11 дээр бүүр тэнээд эрчим хүч, гүн боловсруулалт, говийг усжуулах, шар шуурга цөлжилт ингээд ийм гоё чихрийн цаас зөндөө л байгаа шүү дээ. Тэгэхээр энэ чинь ганцхан юуны асуудал биш байхгүй юу. Тэгээд зүгээр ямар нэгэн тийм одоо ерөөсөө л энэ чинь алсдаа л Монголд хэрэгтэй юм. Нэг их айхтар үндсэн нөгөө юуны хэлэлцээрийн зарчим нь хөндөөд байгаа юмнууд бол нь байхгүй л санагддаг. Сүүлийн юугаа хагас минут тайлбарлачихъя. Угаасаа 3 төрлийн нүүрс гарна. 3 төрлийн нүүрс гаргах болохоор зэрэг бид нар ярьж байгаа гэж та бүхэн хэлж байгаа. Аль алиныг нь нийлүүлнэ гээд, тэр нь мэдээж сайн хэрэг. Өөр угаасаа боломж байхгүй. Гэхдээ анхнаасаа ирсэн албан бичиг дээр нөгөө талаас ирсэн бичиг дээр коксжих нүүрс гэсэн үг байгаа. Тэгээд хэрвээ үнэхээр та нар гурван нүүрс байна гэж ярьж байгаа бол тэр чинь тэнгэрийн юмнаас авахгүй шүү дээ. Яг уурхайнхаа техникийн үндэслэлтэй хэдэн онд хэчнээн хэмжээний олборлох юм. Эхний хэсэгтээ бол коксжих их байгаа. 5 жилийн дараагаас эхлээд коксжих нүүрс чинь багасаад явчихна. Талаасаа бага болно. Цаашаа бүр 30 хувь руу явна. Тэгэхээр аль алийг нь оролцуулах хэрэгтэй. Энэ өгүүлбэрийг энэ дээрээ бичмээр байна. Ийм санал байна. Баярлалаа.

**Р.Сэддорж:** Золжаргал гишүүний гаргасан, Тогтоолын төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалт нэмэх саналын томъёоллоор санал хураалт. 52,4 хувийн саналаар санал дэмжигдлээ. Сайнзориг гишүүнийг дэмжсэнээр протокол тэмдэглэе.

10. Тогтоолын төслийн 1 дэх хэсгийн 7 дугаар заалтын “бүтээн байгуулалтад “Нэг зураг төсөлтэй, нэг гүйцэтгэгчтэй, бүтээн байгуулалтыг зэрэг эхлүүлж, зэрэг дуусгах зарчим баримтлах” гэснийг хасаж, “бүтээн байгуулалтыг нэгдсэн зураг төсөл төлөвлөгөөний дагуу нэгдсэн байдлаар гүйцэтгэх зарчмыг баримтлах” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Батбаярын Жаргалан. Жаргалан гишүүн саналаа тайлбарлая.

**Б.Жаргалан:** Энэ болохлоор бас зүгээр найруулгын шинж чанартай ийм санал байгаа. Яагаад вэ гэхээр нэг зураг төсөлтэй, нэг гүйцэтгэгчтэй бүтээн байгуулалтыг зэрэг эхлүүлж, зэрэг дуусгах гэдэг энэ үг, үсэг нь болохоор нөгөө захидал дээр бас яваад байгаа байхгүй юу. Тэгэнгүүт энийг болохоор яах вэ, ойлгож байгаа ямар агуулга байгаад байгаа юм. Тэгэхээр нэгдсэн зураг төсөл төлөвлөгөөний дагуу нэгдсэн байдлаар гүйцэтгэх зарчмыг баримтлах гээд зүгээр илүү зөөлрүүлж байгаа гэж ойлгох юм уу. Яах вэ, энэ ажлын хэсэг дээр энэ юмнууд чинь бол нэлээн томъёоллын дагуу гарчихсан байх ёстой байгаад байгаа юм. Тэгээд одоо ингээд Их Хурал дээр яр их хэрэг гарчхаад байгаа байхгүй юу. Тэгээд шууд тэр нөгөө захидлаас нь ийм юмнууд аваад оруулчхаж болдог ч юм уу, үгүй ч юм уу тийм ээ.

**Р.Сэддорж:** Жаргалан гишүүний гаргасан саналаар санал хураалт. 14,3 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

11. Тогтоолын төслийн 1 дэх хэсгийн 8 дахь заалтыг бүхэлд нь хасъя гэсэн санал байна. 8 дахь заалт юу юу байгаа билээ. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Батбаярын Жаргалан гишүүний микрофоныг нээе.

**Б.Жаргалан:** Сүүлийнх нь болохоор хардаа. Би 2-т 8 дугаар заалт, 9 дүгээр заалт 2 бол зохимжгүй гэж хараад байгаа юм.

8 дугаар заалт нь болохоор Хятадын талын сонгон шалгаруулсан аж ахуйн нэгжээр энэ тэр гэдэг юмыг бид нар энд ингэж бичих бас шаардлага байгаа юм уу. Тэгээд ингэж байгаа байхгүй юу. Бүтээн байгуулалтын төслийн ажлыг Хятадын талын сонгон шалгаруулсан аж ахуйн нэгжээр төмөр зам, түүнийг холбох барилга байгууламжийг гүйцэтгүүлэн хамтран ажиллах гэгчихсэн.

Үгүй ээ үгүй, харин тэрийг ойлгоод байгаа шүү дээ. тэгээд 7 дугаар заалт дээр нэг байгууламж гэдгээ биччихэж байгаа байхгүй юу. Тэгэхээр хятадын талын сонгон шалгаруулсан гэсэн тэгээд энэ чинь жижигхэн л асуудал байна шүү дээ.

**Р.Сэддорж:** Ингээд асуулт, хариулт байхгүй учраас дэгийн дагуу Жаргалан гишүүний гаргасан ... Жаргалан гишүүн саналаа татчихсан байна. Санал хураах шаардлагагүй боллоо.

Дараа нь Тогтоолын төслийн 1 дэх хэсгийн 9 дэх заалтыг бүхэлд нь хасах гэж байгаа юм байна. Улсын Их Хурлын гишүүн Жаргалан. Жаргалан гишүүн та микрофонд өмнөх саналаа татсан гэдгээ хэлээрэй.

**Б.Жаргалан:** 8 дугаар заалттай холбоотой саналаа татъя. Энэ 9 дүгээр заалтыг бас бүхэлд нь хасах санал оруулж ирсэн байгаа. Энэ нь ямар учиртай вэ гэдэг нь өнгөрсөн хугацаанд Хятадын талд гарсан аливаа ал алдагдал хохирол болон төмөр замын хэл холболтод шаардлагатай хөрөнгө оруулалтын асуудлыг ирээдүйд нэхэмжлүүлэхгүй байх гэсэн заалт байгаад байгаа юм. Тэгэхээр бид нар болохоор одоо Их Хурал Засгийн газарт чиглэл өгөхдөө энийг нь оруулж ирж байна гэдэг чинь Хятадын талд алдаа хохирол гарсан гэдгийг хүлээн зөвшөөрч байгаа явдал мөн юм. Хожим ямар нэгэн маргаан гарлаа гэж үзэхэд танай Их Хурал чинь ингээд Засгийн газартаа чиглэл өгөхдөө тухайн үед Хятадын тал чинь ийм ийм алдаа хохирол амссан гэдгийг хүлээн зөвшөөрч байсан шүү дээ гэсэн нэг ийм зүйл яваад байгаа байхгүй юу. Тэгээд тэр нөгөө Хятадын талаас ирсэн захидал дээр чинь болохоор энэ нэг ийм алдагдсан боломжийн өртөг энэ тэр гээд бүр тоон дүнгүүд тавьчихсан тийм л юм яваад байгаа шүү дээ. Тэгэхээр энэ хэлэлцээр байгуулагдаж байна гэдэг чинь ерөнхийдөө бол тэр өмнөх хойшхи бүх юмнуудаа цэг тавиад, тэгээд урагшаа ирээдүй рүүгээ хараад 16 жилийнхээ гэрээг байгуулаад, нүүрснийхээ борлуулалтыг хийгээд, хил холболтоо хийгээд явъя л гэсэн үг шүү дээ. Тэгэхээр ийм алдагдлыг заавал ингэж бичгээр хүлээн зөвшөөрөөд явж байгаа нь бол зохимжгүй санагдаад байгаа байхгүй юу.

**Р.Сэддорж:** Тогтоолын төслийн 1 дэх хэсгийн 9 дэх заалтыг бүхэлд нь хасах гэсэн саналын томъёоллоор санал хураалт. 19 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Цэнгүүн гишүүнийг дэмжсэнээр, Батчимэг гишүүнийг дэмжсэнээр протоколд тэмдэглэе. Нийт 6 гишүүн.

Тогтоолын төслийн 1 дэх хэсгийн 10 дугаар заалтын “үе шаттайгаар” гэснийг засаж, “зэрэг” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Жаргалан. Жаргалан гишүүн тайлбарлая.

**Б.Жаргалан:** Энэ угаасаа ойлгомжтой. Тэгээд манай талын бас гол хийхийг зорьж байгаа зүйл. Тэгээд энэ дээрээ заавал үе шаттайгаар гэдэг чинь маш тийм бүрхэг, ойлгомжгүй ийм үг, өгүүлбэр байна. Ганц санал дэмжээд өгчихгүй юм уу манайхан.

**Р.Сэддорж:** Жаргалан гишүүний гаргасан саналаар саяын саналын томьёоллоор санал хураалт. 71,4 хувийн саналаар санал дэмжигдлээ. Батсүмбэрэл гишүүнийг дэмжсэнээр протоколд тэмдэглэе.

Тогтоолын төслийн 1.11 дэд заалт нэмэх:

“Харилцан ашигтай” гэсний дараа “хувилбарт шийдэл бүхий гэрээний хүрээнд” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Батнайрамдал. Батнайрамдал гишүүн саналаа тайлбарлая.

**О.Батнайрамдал:** Энэ яах вэ, зүгээр илүү жоохон тодорхой болгож байгаа л санаа байгаа юм. Яагаад гэх юм бол энэ дотроо бид нар чинь зөндөө олон юм дурдчихсан шүү дээ. Сэргээгдэх эрчим хүч, тэгээд говийг усжуулах, тэр битгий хэл шар шар шороон шуурга гээд зорилт бүх зүйл нь тусдаа байж болох байхгүй юу. Тэгэхээр энийг зүгээр харилцан ашигтай тэгээд хувилбар шийдэл бүхий гэрээний хүрээнд хамтран ажиллах гээд засагт илүү ойлгомжтой болгох чиглэл өгөх нь зөв гэж бодож байгаа. Тийм л юм нэмж байгаа. Тэрнээс биш зарчмын том зөрүүтэй өөрчлөлт бол байхгүй. Та бүхэн дэмжээд өгөөрэй.

**Р.Сэддорж:** Батнайрамдал гишүүний гаргасан саналын томьёоллоор санал хураалт. 52,4 хувийн саналаар санал дэмжигдлээ. Алдаржавхлан гишүүнийг дэмжсэнээр протоколд тэмдэглэе.

Тогтоолын 1 дэх заалт заалтад 11 гэсэн шинэ дэд заалт нэмэх:

“11.Байтаг-Улиастайн боомтыг байнгын үйл ажиллагаатай болгох, Булган Такашикен боомтод улсын хилийн 126, 127 дугаар тэмдгийн хооронд авто замаар улсын хилийн шугамыг дайран өнгөрөх цэгийг тохирон хилийн гарц шинээр нэмэх, нүүрс ачиж буулгах талбай, ачаа, тээврийн терминал болон улсын хил дамнасан авто замын бүтээн байгуулалтын ажлыг үе шаттайгаар эхлүүлэх талаар Бүгд Найрамдах Хятад Ард Улсын талтай тохиролцох.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Пүрэвдорж.

Саяын Пүрэвдорж гишүүний гаргасан саналын томьёоллоор санал хураалт 61,9 хувийн саналаар санал дэмжигдлээ. Мандхай гишүүн протоколд тэмдэглэх юм уу. Дэмжсэнээр протоколд Мандхай гишүүнийг нэмье. Одоо дөхөж байна.

Төслийн 1 дэх заалтад 12 дахь дэд заалт нэмэх:

“12.Төмөр замын дамжин өнгөрөх тээврийн хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газрын

хоорондын хэлэлцээрийг байгуулах ажлыг анхаарах.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг. Сайнзориг гишүүн тайлбарлая.

**П.Сайнзориг:** Би энэ хэлэлцээрийн бас ерөнхий зүйлд нөлөөлөхгүйгээр яах вэ, зүгээр энэ асуудлыг бас цаашид анхаараач гэдэг зүйлээр л энэ транзит тээврийн асуудлыг ярьж байгаа. Монгол Улсын экспортыг зөвхөн бид нар урд хөрштэй гэж харж болохгүй. Гуравдагч хөрш рүү бас гарах тэр боломжийг энэ яриа хэлэлцээний хувьд бас ярилцаад, өмнө нь ч энэ оролдлогууд явж байсан. Энэ нөгөө өргөн, нарийн царигаасаа болоод бүх зүйл зогссон байгаа. Өөрөөр хэлэх юм бол Хятадыг чиглэж экспорт хийж байгаа Монголын нийт бараа бүтээгдэхүүний 3-ны 1-тэй тэнцэх энэ бараа бүтээгдэхүүнийг гуравдагч хөрш рүү хөнгөлөлттэй үнээр бас транзит тээвэр хийх эрхийг Монголын талд олгох ийм яриа хэлэлцээ явж байсан. Энийг ер нь нэг цаашдаа бас сэргээж, ярьж бас энэ экспортын хэмжээг нэмэх, бид бас гуравдагч хөрш рүүгээ энэ уул уурхайн бүтээгдэхүүн, бусад Монголоос гарч байгаа бараа бүтээгдэхүүнээ хүргэх, Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн ч байж болно. Ер нь энэ бүх бололцоог бас хангаасай гэж хүсэж байгаа юм. Тэгээд энэ төмөр замыг би харахдаа зөвхөн уул уурхайн бүтээгдэхүүн биш. Энэ бол уурхайн бус гаралтай бараа бүтээгдэхүүнийг тээвэрлэх асуудал байх ёстой. Энэ говийн бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудын бараа бүтээгдэхүүнийг тээвэрлэх ёстой гэж үзэж байгаа юм. Тийм учраас ер нь цаашдаа алсдаа энэ асуудлыг анхаарч зүгээр анхааръя л гэдэг ерөнхий ийм зарчмын юм байгаа. Гишүүд маань тэгээд дэмжээд өгөөч ээ.

**Р.Сэддорж:** Сайнзориг гишүүний гаргасан саналын томъёоллоор санал хураалт. 47,6 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй. Энхтүвшин гишүүн горимын санал гаргая.

**Д.Энхтүвшин:** Сая хуруу уншигдсангүй. Тэгэхээр саяын санал хураалтыг хүчингүй болгоод, дахиж санал хураалт явуулж өгөхийг хүсье.

**Р.Сэддорж:** Энхтүвшин гишүүний гаргасан горимын саналаар сүүлийн санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн томъёоллоор санал хураалт хүчингүй болгохыг дэмжье гэсэн томъёоллоор. 52,4 хувийн саналаар дэмжигдэж, санал хураалт хүчингүй боллоо. Санал хураалтыг дахиж явуулъя.

Төслийн 1 дэх заалтад 12 дахь дэд заалт нэмэх:

“12.Төмөр замын дамжин өнгөрөх тээврийн хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг байгуулах ажлыг анхаарах.” гэсэн Сайнзориг гишүүний гаргасан саналын томъёоллоор санал хураалт. 61.9 хувийн саналаар санал дэмжигдлээ. Батчимэг гишүүнийг дэмжсэнээр протоколд тэмдэглэе.

Шинэ 13 дахь заалт нэмэх:

“13.Бүтээн байгуулалтын болон олборлолтын бүх л үе шатад Монгол улсын аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг. Сайнзориг гишүүн саналаа тайлбарлая.

**П.Сайнзориг:** Хэлэлцээрт нэг их нөлөөлөхгүй байх. Ер нь бол бүтээн байгуулалт, олборлолт, эргээд энэ тээвэрлэлтийн үйл ажиллагаа дээр Монголын аж ахуйн нэгж, байгууллагыг бас оролцуулах асуудлыг зүгээр зарчмын хувьд

хөндөж тавих ёстой. Тэгэхээр энийг бас зүгээр тусгаад оруулчихъя. Ер нь зүгээр том зургаараа хэлэлцээр дээр бас зайлшгүй үлдээх ёстой. Тэгээд ер нь зүгээр протоколын хувьд тэр дээр санал хураахгүй. Протоколын хувьд үлдээж байгаа юм нь энэ “Чайна энерги”-тэй энэ хэлэлцээрийг хийсэн тохиолдолд бас яг тодорхой чиглэлээр химийн инженерүүдийг бэлдэх, энэ бүтээн байгуулалтын явцад ядаж хэдэн төмөр замын нарийн ажиллах боловсон хүчнийг бас бага ч гэсэн бэлдээд авах хэрэгтэй. Ер нь ийм зүйлүүд рүү бас бид нар анхаарч байж Монгол Улсад дараа дараагийн хөрөнгө оруулалт дээр бид нар ч гэсэн төсөл дээр ажиллах боловсон хүчин гарна шүү. Энийг зүгээр протоколын хувьд бас үлдээчихье. Тэгээд аль болохоор Монголын аж ахуйн нэгж, байгууллагын оролцоог хангаж асуудлыг зарчмын хувьд дуугарах нь зөв л гэж санал хураалгаж байгаа шүү. Та бүгд дэмжээд өгөөрэй.

**Р.Сэддорж:** Саяын гаргасан саналын томъёоллоор санал хураалт. 57,1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Шинэ 14 дэх заалт нэмэх:

“Төмөр замын ачаа тээвэрт 2 тал тэгш эрхтэй байх, Монгол Улсын бусад компаниудын ачааг тээвэрлэх боломжтой байх.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Алдаржавхлан. Алдаржавхлан гишүүн саналаа тайлбарлая.

**Ж.Алдаржавхлан:** За энэ нөгөө төмөр замын холболт хийгдсэнээр ачаа тээврийн дан ганц “Чайна Энержи” гэдэг компани давуу байдал олгохгүйн тулд тэгш эрхтэй л ачаа тээврээ ашиглая л гэж байгаа юм. Тэгээд энэ маань бас манай намын бүлэг дээр дэмжигдчихсэн ийм санал байгаа. Тэгээд би бас энийг дахиж Эдийн засгийн байнгын хороо дээр гаргаж байгаа юм. Тэгээд тэгш эрхтэй ашиглахгүй бол ер нь тэгээд “Чайна Энержи” гээд баахан тээвэр яваад байдаг болчих вий л гэж байгаа юм. Тиймээс 2 талын зарчмыг оруулъя л гэж байгаа юм. Тэгээд та бүгдийг бас дэмжиж өгөөч гэж хүсэж байна. Сайд дэмжиж байгаа.

**Р.Сэддорж:** Саяын Алдаржавхлан гишүүний гаргасан саналын томъёоллоор санал хураалт. 71,4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Тогтоолын төслийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтад “Төмөр замын бүтээн байгуулалтын” гэснийг “төмөр замын тээврийн хүчин чадал” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Энхтүвшин. Энхтүвшин гишүүн саналаа тайлбарлая.

**Д.Энхтүвшин:** Энэ дээр хэд хэдэн нэр томъёонууд нь зөрүүтэй юмнууд байна лээ. Тэр түрүүн Дээгий сайд бас хэлсэн. Эдийн засгийн үр ашиг бас энэ дээр эдийн засгийн үр ашиг, үр өгөөж гээд дараа нь бас санал байгаа. Энийг одоо хүчин чадалтай, нөгөө ачааныхаа төмөр замынхаа ачааны хүчин чадлыг баталгаажуулах үүднээс ийм санаанууд оруулчихсан байгаа. Тэгэхээр энэ нүүрс худалдаж, худалдан авах гэрээ хийхдээ эдийн засгийн үр ашгаас гадна энэ тээврийн хүчин чадал гэдэг юмнуудаа давхар оруулж явахгүй бол зөвхөн дан эдийн засгийн үр ашиг гэвэл бас нөгөө нүүрс худалдаж, худалдан авах гэрээ маань бас үргэлжилж явахааргүй харагдаад байгаа учраас энэ тээврийн хүчин чадал гэдэг байдлаар энэ бүтээн байгуулалт гэдгийг нь төмөр замын тээврийн хүчин чадал, эдийн засгийн үр ашгийг хангах зорилгоор гэж найруулах ийм саналтай байгаа юм. Дэмжиж өгөхийг хүссэн юм. Дээгий сайдын л хэлсэн юмыг л засаж байгаа юм.

**Р.Сэддорж:** Саяын саналын томъёоллоор санал хураалт. 61,9 хувийн саналаар санал дэмжигдлээ. Алдаржавхлан гишүүнийг дэмжсэнээр протоколд тусгая.

Тогтоолын төслийн 1 дэх заалтын 11 дэх дэд заалтын “сэргээгдэх эрчим хүчний экспорт, эрчим хүчний нүүрс экспортлох, нүүрсний гүн боловсруулах аж үйлдвэржилт, говийг усжуулах, шар шороон шуурга, цөлжилттэй тэмцэх, хил холболт болон дэд бүтцийн бүтээн байгуулалт, орон нутгийн хөгжлийг дэмжих, орон нутагт ажлын байр шинээр бий болгох” гэж нэмэх. Миний бие санал гаргаж байна.

Ингээд бүх бүтээн байгуулалт юмнууд чинь орон нутаг дээр очоод боож ажиллана. Зөвшөөрөл, хайрга дайргаас авхуулаад л. Тэгэхээр энэ боомтыг орон нутагт ард иргэдэд ээлтэй, улам илүү ээлтэй болгох, одоо ерөөсөө иргэдэд бол ээлгүй болчихсон нэртэй ийм байгаа. Орон нутгийн уугуул иргэд, ялангуяа хуучин, Ханбогд, хуучин тэр хавийн сумуудын иргэдэд бол газар байхгүй, орон зай байхгүй гэж ярьдаг. Тийм учраас энэ заалтыг оруулах зүйтэй байх гээд. Та бүхэн маань дэмжээд өгөөрэй. Санал хураалт. 71,4 хувийн саналаар санал дэмжигдлээ. Жаргалан гишүүн дэмжсэнээр протоколд тэмдэглээ.

Тогтоолын төслийн 3 дахь заалтад үг, үсгийн юм байгаа юм байна. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо /Г.Тэмүүлэн/-д даалгасугай.” гэсний дараа “Эдийн засгийн байнгын хороо” гэж нэмэх. Санал хураалт. 81 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Дараагийн санал. “Саналууд дэмжигдсэнтэй холбогдуулан дугаарлалтыг өөрчлөх” Санал гаргасан байнгын хорооны дарга. Саналууд өөрчлөгдсөнтэй холбогдуулан дугаарлалтыг өөрчлөх дугаарлалт. Санал хураалт. 76,2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Нэр томъёо, үг хэллэгийн жигдлэх найруулгын санал:

1.“Гашуун сухайт-Ганц мод чиглэлийн төмөр замын тээврийн” гэснийг “Монгол Хятадын хилийн Гашуун сухайт-Ганц мод боомтын хил дамнасан төмөр замын” гэж тухай бүр жигдлэх.

2.“Эдийн засгийн үр ашиг” гэснийг “Эдийн засгийн өгөөж” гэж тухай бүрт жигдлэх.

3.“Тээврийн багтаамж” гэснийг “тээврийн хүчин чадал” гэж тухай бүр жигдлэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Энхтүвшин. Энхтүвшин гишүүн саналаа тайлбарлая.

**Д.Энхтүвшин:** Нөгөө үг, хэлийг нь харахаар Хилийн Гашуун сухайт-Ганц боомтын тэгснээ 1 болохоор Монгол Хятадын Гашуун сухайт боомтын гэдэг, эсвэл зүгээр Гашуун сухайт-Ганц мод чиглэлийн төмөр замыг эднийг 1 дүгээрт нь жигдлэх хэрэгтэй гэсэн санал байгаа юм.

2-т нь болохоор 1 юун дээр болохоор эдийн засгийн өгөөжийг хангах зорилгоор, нөгөөдөх дээр нь 2 дээр болохоор үр ашгийг хангах зорилгоор гэгчихсэн

нэг ижилхэн агуулгатай юмыг 2 өөрөөр бичсэн байсныг нь өгөөж гээд жигдлэх гэсэн санал байгаа.

3 дахь нь болохоор төмөр замын тээврийн хүчин чадал гэж нэг байгаа. Төмөр замын тээврийн багтаамж гэж 1 ижилхэн юмыг бас 2 өөрөөр хэлчихсэн байсныг нь бүгдийг нь тээврийн хүчин чадал гээд жигдэлчихвэл яасан юм бэ гэсэн ийм найруулгын шинжтэй санал байгаа.

**Р.Сэддорж:** Гишүүд зарчмын агуулгатай гэж үзэж байгаа бол 1, 1-ээр нь санал хураая.

Ингээд сая Энхтүвшин гишүүний гаргасан 1 дүгээр санал.

“Монгол Хятадын хилийн Гашуун сухайт-Ганц мод чиглэлийн төмөр замын тээврийн” гэснийг “Монгол Хятадын хилийн Гашуун сухайт-Ганц мод боомтын хил дамнасан төмөр зам” гэж жигдлэх. Энэ дээр санал хураая. 38,1 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

2. “Эдийн засгийн үр ашиг” гэснийг “эдийн засгийн үр өгөөж” гэж өөрчлөх. Санал хураалт. 42,9%-ийн саналаар санал дэмжигдсэнгүй.

3. “Тээврийн багтаамж” гэснийг “тээврийн хүчин чадал” гэж өөрчлөх санал гаргасан Энхтүвшин гишүүн. Санал хураалт. 61,9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналуудаар санал хураалт явуулж дууслаа.

Тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Лодойсамбуу уншиж танилцуулна.

“Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд Гашуунсухайт-Ганц мод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх хэлэлцээрийг байгуулахад баримтлах үндсэн чиглэлийг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Эдийн засгийн байнгын хорооны өнөөдрийн хуралдаан өндөрлөж байна. Гишүүддээ баярлалаа. Ажлын хэсгийн гишүүддээ баярлалаа.

22.16 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ  
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:  
ШИНЖЭЭЧ*

*Э.СУВД-ЭРДЭНЭ*